



# БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮЖИЛТИЙН БАЙДАЛ

2021 ОНЫ ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ҮР ДҮН

МОНГОЛБАНК  
СУДАЛГАА СТАТИСТИКИЙН ГАЗАР  
ТҮҮВЭР СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБА



2021 ОН

## АГУУЛГА

1.	ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ _____	7
2.	БИЗНЕСИЙН ОРЧИН _____	12
2.1	Макро эдийн засгийн орчин _____	13
2.2	Нийгэм, улс төрийн байдал _____	1
2.3	Хууль, эрх зүй, төрийн зохицуулалтын орчин _____	17
2.4	Зах зээлийн орчин _____	20
2.5	Дэд бүтцийн хөгжил _____	22
2.6	Санхүүжилтийн орчин _____	25
2.7	Дотоод хүчин зүйлс _____	29
3.	БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА _____	32
3.1	Орлого _____	32
3.2	Зардал _____	34
3.3	Хүчин чадлын ашиглалт _____	38
4.	БИЗНЕСИЙН САНХҮҮЖИЛТ, ДЭМЖЛЭГ _____	43
4.1	Дэмжлэг _____	43
4.2	Санхүүжилт _____	44
5.	ЦАР ТАХАЛ, ЗГ-ЫН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН НӨЛӨӨ _____	50
6.	ДҮГНЭЛТ _____	52
7.	Хавсралт _____	53
7.1	Асуулгын хуудас _____	53

## ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Дүрслэл 1.1   Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн бүтэц.....	8
Дүрслэл 1.2   Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн үйл ажиллагааны чиглэл .....	9
Дүрслэл 1.3   Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн үйл ажиллагааны төрөл, ажиллагчдын тоо .....	9
Дүрслэл 1.4   Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн жилийн нийт орлого .....	9
Дүрслэл 1.5   Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн орлого, аймгуудаар .....	10
Дүрслэл 1.6   Аж ахуйн нэгжийн хэмжээний ангилал, салбараар.....	10
Дүрслэл 2.1   Бизнесийн орчны ерөнхий индекс .....	12
Дүрслэл 2.2   Бизнесийн орчны ерөнхий индекс, бүлэг тус бүрээр.....	12
Дүрслэл 2.3   Макро эдийн засгийн орчин .....	13
Дүрслэл 2.4   Макро эдийн засгийн орчин, үзүүлэлтээр.....	13
Дүрслэл 2.5   Макро эдийн засгийн орчин, салбараар .....	14
Дүрслэл 2.6   Макро эдийн засгийн орчин, ААН-ийн хэмжээгээр .....	14
Дүрслэл 2.7   Макро эдийн засгийн орчин, аймаг болон дүүргээр .....	1
Дүрслэл 2.8   Нийгэм, улс төрийн байдал.....	1
Дүрслэл 2.9   Нийгэм, улс төрийн байдал, үзүүлэлтээр .....	16
Дүрслэл 2.10   Нийгэм, улс төрийн байдал, үзүүлэлтээр .....	16
Дүрслэл 2.11   Нийгэм, улс төрийн байдал, ААН-ийн хэмжээгээр.....	16
Дүрслэл 2.12   Нийгэм улс төрийн байдал, аймаг болон дүүргээр .....	17
Дүрслэл 2.13   Хууль, эрх зүй, төрийн зохицуулалт.....	18
Дүрслэл 2.14   Хууль, эрх зүй, төрийн зохицуулалт, үзүүлэлтээр .....	18
Дүрслэл 2.15   Хууль, эрх зүй, төрийн зохицуулалт, салбараар.....	18
Дүрслэл 2.16   Хууль, эрх зүй, төрийн зохицуулалт, ААН-ийн хэмжээгээр.....	19
Дүрслэл 2.17   Хууль, эрх зүй, төрийн зохицуулалт, аймаг болон дүүргээр .....	19
Дүрслэл 2.18   Зах зээлийн орчин.....	20
Дүрслэл 2.19   Зах зээлийн орчин, үзүүлэлтээр .....	20
Дүрслэл 2.20   Зах зээлийн орчин, салбараар .....	22
Дүрслэл 2.21   Зах зээлийн орчин, ААН-ийн хэмжээгээр.....	22
Дүрслэл 2.22   Зах зээлийн орчин, аймаг болон дүүргээр.....	22
Дүрслэл 2.23   Дэд бүтцийн хөгжил.....	23
Дүрслэл 2.24   Дэд бүтцийн хөгжил, үзүүлэлтээр .....	23
Дүрслэл 2.25   Дэд бүтцийн хөгжил, салбараар .....	24
Дүрслэл 2.26   Дэд бүтцийн хөгжил, ААН-ийн хэмжээгээр.....	24

Дүрслэл 2.27   Дэд бүтцийн хөгжил, аймаг болон дүүргээр.....	25
Дүрслэл 2.28   Санхүүжилтийн орчин .....	25
Дүрслэл 2.29   Санхүүжилтийн орчин, үзүүлэлтээр.....	26
Дүрслэл 2.30   Санхүүжилтийн орчин, салбараар .....	27
Дүрслэл 2.31   Санхүүжилтийн орчин, ААН-ийн хэмжээгээр .....	27
Дүрслэл 2.32   Санхүүжилтийн орчин, аймаг болон дүүргээр .....	28
Дүрслэл 2.33   Дотоод хүчин зүйлс .....	29
Дүрслэл 2.34   Дотоод хүчин зүйлс, үзүүлэлтээр.....	29
Дүрслэл 2.35   Дотоод хүчин зүйлс, салбараар .....	30
Дүрслэл 2.36   Дотоод хүчин зүйлс, ААН-ийн хэмжээгээр .....	30
Дүрслэл 2.37   Дотоод хүчин зүйлс, аймаг болон дүүргээр.....	30
Дүрслэл 3.1   Өмнөх онтой харьцуулахад орлого өөрчлөгдсөн эсэх.....	32
Дүрслэл 3.2   2020, 2021 оны орлогын өөрчлөлтийн харьцуулалт.....	32
Дүрслэл 3.3   Орлогын өөрчлөлт, аймгуудаар.....	32
Дүрслэл 3.4   Орлогын өөрчлөлт, салбараар .....	33
Дүрслэл 3.5   Орлогын өөрчлөлт, ААН-ийн хэмжээгээр .....	33
Дүрслэл 3.6   ААН-ийн бизнесийн орлогын бүтэц.....	33
Дүрслэл 3.7   Орлого нэмэгдүүлэх боломж.....	33
Дүрслэл 3.8   Өмнөх онтой харьцуулахад зардал өөрчлөгдсөн эсэх .....	34
Дүрслэл 3.9   2020, 2021 оны зардлын өөрчлөлтийн харьцуулалт.....	34
Дүрслэл 3.10   Зардлын өөрчлөлт, аймгуудаар .....	34
Дүрслэл 3.11   Зардлын өөрчлөлт, салбараар .....	35
Дүрслэл 3.12   Зардлын өөрчлөлт, ААН-ийн хэмжээгээр.....	35
Дүрслэл 3.13   Зардал бууруулах боломж.....	35
Дүрслэл 3.14   Зардлын байдал, чиглэлийн индекс .....	36
Дүрслэл 3.15   Зардлын байдал, салбараар .....	36
Дүрслэл 3.16   Зардлын байдал, ААН-ийн хэмжээгээр.....	36
Дүрслэл 3.17   Зардлын байдал, үзүүлэлтээр .....	37
Дүрслэл 3.18   Зардлын байдал, аймаг болон дүүргээр.....	38
Дүрслэл 3.19   Хүчин чадлын ашиглалт .....	39
Дүрслэл 3.20   Хүчин чадлын ашиглалт, ААН-ийн хэмжээ, байршлаар.....	39
Дүрслэл 3.21   Хүчин чадлын ашиглалт, салбараар .....	39
Дүрслэл 3.22   Ажилчдын тоо, байршлаар .....	40
Дүрслэл 3.23   Ажилчдын тоо, салбараар .....	40

Дүрслэл 3.24   Ажилчдын тоо, ААН-ийн хэмжээгээр.....	40
Дүрслэл 3.25   Нэг ажилтны өдөрт ажиллах цагийн дундаж, байршлаар .....	40
Дүрслэл 3.26   ААН-ийн сарын дундаж орлого, байршлаар.....	41
Дүрслэл 4.1   ААН-үүдийг хамгийн ихээр дэмждэг байгууллага .....	43
Дүрслэл 4.2   Бизнесийн байгууллагад ирж буй дэмжлэг .....	43
Дүрслэл 4.3   Бизнесийг хөгжүүлэхэд нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ.....	44
Дүрслэл 4.4   Бизнесийн байгууллагад ирж буй дэмжлэг, эрэмбийн өөрчлөлт.....	44
Дүрслэл 4.5   Санхүүжилтийн эх үүсвэр, ААН-ийн хэмжээгээр.....	44
Дүрслэл 4.6   Санхүүжилтэд хамрагдсан байдал, салбараар .....	45
Дүрслэл 4.7   Санхүүжилтийн эх үүсвэр.....	45
Дүрслэл 4.8   Санхүүжилт авахад тулгарч буй хүндрэлүүд.....	45
Дүрслэл 4.9   Санхүүжилтийн зарцуулалт.....	46
Дүрслэл 4.10   Санхүүжилтийн зарцуулалт, салбараар.....	47
Дүрслэл 4.11   Санхүүжилтээ эргэн төлөхөд тулгардаг бэрхшээл.....	47
Дүрслэл 4.12   Үйл ажиллагаанд дэмжлэг санхүүжилтийн хэмжээ .....	47
Дүрслэл 4.13   Бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хугацаа, салбараар .....	48
Дүрслэл 4.14   Бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх санхүүжилтийн хэмжээ, хугацаа, ААН-ийн хэмжээгээр .....	48
Дүрслэл 4.15   Бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх санхүүжилтийн хэмжээ, хугацаа, ААН-ийн хэмжээгээр .....	48
Дүрслэл 4.16   Бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх санхүүжилтийн хэмжээ, хугацаа, байршлаар.....	48
Дүрслэл 5.1   Цар тахалтай холбоотойгоор цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ .....	50
Дүрслэл 5.2   Засгийн газраас хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдээс эерэг нөлөө үзүүлж, дэмжлэг болсон арга хэмжээ.....	50
Дүрслэл 5.3   Засгийн газраас хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн зарцуулалт /2021.07.01-ний байдлаар/.....	51
Дүрслэл 5.4   Ажлын байрыг хадгалах 3 хувийн хүүтэй зээлд хамрагдсан эсэх.....	51
Дүрслэл 5.5   Ажлын байрыг хадгалах 3 хувийн хүүтэй зээлд хамрагдаагүй шалтгаан.....	51
Дүрслэл 5.6   Гадаад худалдаанд ачаа тээврийн гацалт үүссэн эсэх.....	51
Дүрслэл 5.7   Гадаад худалдаанд ачаа тээврийн гацалт нөлөөлсөн байдал .....	51

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1   Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн тоо.....	7
Хүснэгт 2   Үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо, ажиллагчдын тооны бүлгээр .....	8
Хүснэгт 3   Зардлын байдал, салбараар .....	38
Хүснэгт 4   Зардлын байдал, ААН-ийн хэмжээгээр .....	38
Хүснэгт 5   Тоног төхөөрөмж ашиглалт .....	39

## ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ

Шигтгээ 1: Цар тахлын үед Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд: .....	13
Шигтгээ 2: Хүний хөгжлийн индекс (human development index (HDI)).....	16
Шигтгээ 3: Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем “e-Mongolia”-ийн тухай.....	18
Шигтгээ 4: Өрхийн дундаж орлого, зардлын болон хадгаламжийн үзүүлэлт.....	21
Шигтгээ 5: Дэд бүтцийн талаарх зарим мэдээлэл .....	23
Шигтгээ 6: Урт хугацаат репо арилжааны хөнгөлөлттэй зээлийн тухай.....	26
Шигтгээ 7: ААН-ийн бодит орлого, зардлын өсөлт .....	35
Шигтгээ 8: Улсын төсвийн орлого.....	37
Шигтгээ 9: Ажиллагчдын тоо.....	40
Шигтгээ 10: Банкуудын ААН-үүдэд олгох зээлийн шалгуур, нөхцөлд гарсан өөрчлөлт .....	45



## ӨМНӨХ ҮГ

Жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ) нь хөгжиж буй орнуудын бизнес эрхлэгчдийн дийлэнх хувийг эзэлдэг бөгөөд ажлын байр бий болгох замаар эдийн засгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулдаг байна. Тухайлбал, Дэлхийн банкны судалгааны үр дүнгээс харахад ЖДҮ нь бизнесийн 90 орчим хувь, ажил эрхлэлтийн 50 гаруй хувийг дангаар бүрдүүлдэг байна. Иймд ЖДҮ-ийн салбарыг дэмжих, хөгжүүлэх нь ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулахын зэрэгцээ хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгох гол тулгуур болдог байна. Манай улсын хувьд ч гэсэн бизнес эрхлэгчдийн дийлэнх олонхийг ЖДҮ эрхлэгчид бүрдүүлж байна. Иймээс ЖДҮ-ийн нөхцөл байдал, санхүүжилтийн байдлыг тодорхойлох зорилгоор Монголбанкны зүгээс 2011 оноос хойш жил бүр, улс орон даяар ЖДҮ-ийн түүвэр судалгааг зохион байгуулж ирлээ.

Энэхүү судалгааг явуулж эхэлснээс хойш ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн орчин хувьсан өөрчлөгдөж байгаа тул жил бүрийн судалгаанд тухайн үеийн нөхцөл байдалд тохирсон цаг үеийн шинжтэй бүлэг асуулгуудыг нэмэлтээр оруулахын зэрэгцээ хамрах хүрээг өргөтгөж, 2020 оноос эхлэн ЖДҮ-ээс бусад аж ахуйн нэгжүүдийг судалгаанд хамруулж эхэллээ. Энэ жилийн түүвэр судалгааны тухайд цар тахлын үеийн бизнесийн үйл ажиллагааны нөхцөл байдлыг тодорхойлж, үнэлж буйгаараа онцлог болж байна.

Төр засгийн зүгээс ч ЖДҮ эрхлэгчдийг дэмжих, бизнесийн орчинг дэмжихэд нэлээдгүй ач холбогдол өгч, ЖДҮ эрхлэгч нарыг дэмжих тусгайлсан бодлого боловсруулж, хэрэгжүүлж байна. Тухайлбал, 2019 онд “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай” хууль батлагдаж, эрх зүйн орчин шинэчлэгдсэн төдийгүй “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний

хөтөлбөр” батлагдлаа. Мөн ЖДҮ-ийг дэмжих тусгай сангууд бий болж, төрийн байгууллагуудад энэхүү чиглэлд тусгайлсан үйл ажиллагаатай агентлаг, газруудыг байгуулав.

Монголбанкны зүгээс эдийн засаг, бизнес эрхлэгчдийг дэмжих хүрээнд зээлийн хүүг бууруулах, хөнгөлөлттэй зээл олгох, санхүүжилтийн хүртээмжтэй тогтолцоог бий болгох, уул уурхайн бус экспортыг дэмжихэд чиглэсэн үйлдвэрлэлийг дэмжих зэрэг арга хэмжээг тухай бүр авч ажиллаж байна. Энэ ч утгаараа “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэл”-д санхүүгийн секторын тогтвортой байдалтай нийцтэйгээр бизнес эрхлэгчдийг дэмжих, орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бүрдүүлэх, “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн хэрэгжилтийг хангах, ажлын байрыг дэмжих зээлийн хөтөлбөрийг үргэлжлүүлэх зэрэг заалтуудыг тусгаж, УИХ-аар батлууллаа.

Судалгааны ажил нь үндсэн 5 бүлгээс бүрдэх бөгөөд нэгдүгээр бүлэгт тус судалгааны ажлын ач холбогдол, түүвэр судалгаанд ашигласан арга аргачлалын талаар орууллаа. Харин судалгааны ажлын үндсэн бүлэг буюу хоёрдугаар бүлэгт бизнесийн орчны нөхцөл байдлыг үндсэн 7 хэсэгт хуваан судлав. Гуравдугаар бүлэгт бизнес эрхлэгчдийн дотоод үйл ажиллагаа болон орлого, зарлагын талаар дэлгэрэнгүй авч үзлээ. Дөрөвдүгээр бүлэгт бизнес эрхлэгчдийн санхүүжилт авахтай холбоотой үүсч буй хүндрэл, бэрхшээлүүд болон төрийн байгууллагууд хэрхэн дэмжлэг үзүүлж буйг тодорхойлсон бол сүүлийн бүлэгт цар тахалтай холбоотой төрийн зүгээс авч хэрэгжүүлсэн бодлого, төсөл хөтөлбөрийн нөлөө бизнес эрхлэгчдэд хэрхэн тусч буйг тодорхойлж харуулахыг оролдлоо.

## 1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

**Зорилго:** Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсад бизнес эрхэлж буй аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаа, ажил эрхлэлт, хүчин чадал, санхүүжилт, бизнесийн орчин, төрийн болон бусад дэмжлэгийн талаар судалж, саад бэрхшээлийг тодорхойлж, бодлогын шийдвэр гаргалтад ашиглах мэдээллийг боловсруулахад оршино.

Монголбанкнаас өмнө нь 8 удаагийн түүвэр судалгаагаар жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ)-ийн өнөөгийн байдал, түүнд нөлөөлөгч хүчин зүйлс, тулгарч буй саад бэрхшээл болон санхүүжилтийн нөхцөл байдал, төрийн болон бусад дэмжлэгүүдийн талаарх түүвэр судалгааг явуулж байсан.

Энэ удаагийн судалгаагаар Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны бизнес регистрийн санд бүртгэлтэй бизнес эрхлэгчдийг үйл ажиллагааны чиглэл, ажиллагчдын тооны бүлэг тус бүрээр ангилах замаар оновчтой түүвэрлэлтийг хийж, аж ахуйн нэгжүүдийг санамсаргүй байдлаар сонгов. Түүнчлэн бизнесийн орчин, үйл ажиллагаа, бизнесийн санхүүжилт, дэмжлэг, цар тахал болон засгийн газрын төсөл хөтөлбөрийн нөлөөг тооцох зорилгоор холбогдох асуулгуудыг авч, тайланд тусгалаа.

**Аргачлал:** Судалгааны мэдээллийн санг санал асуулга явуулах замаар цуглуулсан бөгөөд судалгаанд голлон гүйцэтгэх удирдлага, холбогдох албан тушаалтнаас ярилцлагын аргаар мэдээлэл авсан болно.

**Түүвэрлэлт:** Судалгааны түүвэрлэлтийн нэгжийг сонгохдоо ААН-үүдийн байршил, ажиллагчдын тоо, орлого болон үйл ажиллагааны чиглэлийг харгалзан үзэж, эх олонлогийг төлөөлөхүйц түүврийг санамсаргүйгээр сонголоо. Түүврийн эх олонлогоор 2021 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар ҮСХ-ны бизнес регистрийн санд бүртгэлтэй, үйл ажиллагаа

явуулж буй **93,560** аж ахуйн нэгжүүдийг сонгон авав.

**Хүснэгт 1 | Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн тоо**

Аймаг	Үйл ажиллагаа явуулж буй ААН			Судалгаанд хамрагдсан ААН		
	Тоо	Хувийн жин	Төлөвлөсөн	Авсан	Хувийн жин	Нийт ААН-д эзлэх хувь
1 Архангай	1,027	1.1%	23	23	3%	2.2%
2 Баян-Өлгий	1,415	1.5%	32	32	5%	2.3%
3 Баянхонгор	1,323	1.4%	30	34	5%	2.6%
4 Булган	1,199	1.3%	28	28	4%	2.3%
5 Говь-Алтай	808	0.9%	19	19	3%	2.4%
6 Говьсүмбэр	320	0.3%	9	9	1%	2.8%
7 Дархан-Уул	2,341	2.5%	53	54	8%	2.3%
8 Дорноговь	1,106	1.2%	25	25	4%	2.3%
9 Дорнод	1,623	1.7%	37	37	6%	2.3%
10 Дундговь	626	0.7%	14	14	2%	2.2%
11 Завхан	1,290	1.4%	30	30	4%	2.3%
12 Орхон	1,883	2.0%	42	42	6%	2.2%
13 Өвөрхангай	1,297	1.4%	29	34	5%	2.6%
14 Өмнөговь	1,860	2.0%	41	41	6%	2.2%
15 Сүхбаатар	744	0.8%	17	17	3%	2.3%
16 Сэлэнгэ	2,444	2.6%	55	55	8%	2.3%
17 Төв	1,156	1.2%	27	27	4%	2.3%
18 Увс	1,536	1.6%	35	35	5%	2.3%
19 Ховд	2,095	2.2%	48	50	7%	2.4%
20 Хөвсгөл	1,629	1.7%	37	37	6%	2.3%
21 Хэнтий	1,158	1.2%	27	27	4%	2.3%
Орон нутаг	28,880	30.9%	658	670	31%	2.3%
Улаанбаатар	64,680	69.1%	1,476	1,476	69%	2.3%
<b>Нийт</b>	<b>93,560</b>	<b>100%</b>	<b>2,134</b>	<b>2,146</b>	<b>100%</b>	<b>2.3%</b>

Статистик тооцооллоос оновчтой түүврийн хэмжээг Улаанбаатар хотоос **1,476**, аймгуудаас **658** байхаар төлөвлөж, мэдээлэл бүрэн бөгөөд түүвэр судалгааны чанарын шаардлага хангасан **2,146** түүвэр цуглууллаа. Санал асуулгад оролцогчдыг аймаг, нийслэлээр авч үзвэл нийт оролцогчдын 69%-ийг Улаанбаатар хот, 31%-ийг орон нутгийн бизнес эрхлэгчид эзэлж байгаа бөгөөд үйл ажиллагаа эрхэлж буй нийт аж ахуйн нэгжид эзлэх хувийн жинг харвал ихэнх аймгуудад 2-3%-ийн хооронд жигд тархалттайгаар судалгаанд хамрагдлаа /Хүснэгт 1/.

Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй нийт 93,560 ААН-үүдийн 2.3% нь судалгаанд хамрагдсан бөгөөд Архангай, Орхон, Дундговь, болон Өмнөговь аймгийн 2.2%, Говьсүмбэр аймгийн 2.8%, Улаанбаатар



хотын 2.3%, бусад аймгуудад 2.3-2.6% нь хамрагдсан байна.

Бизнес регистрийн санд бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн 88% нь 1-9 ажилчинтай, 10% нь 10-49 ажилчинтай, 3% нь 50-иас дээш тооны ажилчидтай байна /Хүснэгт 2/.

### Хүснэгт 2 | Үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо, ажиллагчдын тооны бүлгээр

Ажиллагчдын тооны бүлэг	ААН-ийн тоо	Хувийн жин
1-9 хүнтэй	81,995	88%
10-49 хүнтэй	8,974	10%
50-аас дээш	2,591	3%
<b>Нийт</b>	<b>93,560</b>	<b>100%</b>


Эх сурвалж: ҮСХ

**ААН-ийн өмчлөл, эзэмшлийн хэлбэр, хугацаа:** Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн хариуцлагын хэлбэрийг авч үзвэл дийлэнх нь буюу 95% нь хязгаарлагдмал хариуцлагатай компани эзэлж байна. Харин нөхөрлөл 2%, хувиараа эрхлэх аж ахуй 1%, хоршоо 1%-ийг бүрдүүлж байна. Түүнчлэн хөрөнгө оруулалтын хэлбэрээр нь ангилбал дийлэнх нь буюу 96% нь дотоодын хөрөнгө оруулалттай, харин гадаадын хөрөнгө оруулалттай 3%, холимог хөрөнгө оруулалттай бизнес 1%-ийг тус тус бүрдүүлжээ.


Бизнес эрхлэгчдийг үйл ажиллагаа эрхэлж буй хугацаагаар ангилбал 6% нь 1 жил хүртэлх, 19% нь 1-3 жил, 14% нь 3-5 жил, 27% нь 5-10 жил, 26% нь 10-20, 6% нь 20-30, 1% нь 30-аас дээш жил үйл ажиллагаа эрхэлж байна.

### Дүрслэл 1.1 | Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн бүтэц


#### Хариуцлагын хэлбэрээр



#### Хөрөнгө оруулалтын хэлбэрээр




#### Үйл ажиллагаа эрхэлж буй хугацаагаар



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

**ААН-ийн үйл ажиллагааны чиглэл:** Санал асуулгад оролцогчдын ихэнх нь буюу 44% нь дотоод худалдаа, 25% нь үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол 12% нь барилга, 10% нь аж үйлдвэр, 9% нь ХАА салбарт тус тус үйл ажиллагаа явуулж байна.

**Дүрслэл 1.2 | Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн үйл ажиллагааны чиглэл**




Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

**Ажиллагчдын тооны бүлэг:** Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд заасан ажиллагчдын тооны шалгуураар бизнесүүдийг ангилбал судалгаанд оролцсон ААН-үүдийн 83% нь 1-9 хүртэлх буюу “бичил”, 11% нь 10-49 хүртэлх тооны ажилчидтай буюу “жижиг” үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч байна. Харин 4% нь 50-200 хүртэлх тооны ажилчидтай буюу “дунд” ангилалд хамаарах аж ахуйн нэгжүүд байгаа бол 200-аас дээш тооны ажилчидтай буюу “том” ААН-үүд нийт оролцогчдын 5%-ийг бүрдүүлж байна /Дүрслэл 1.3/.

**Дүрслэл 1.3 | Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн үйл ажиллагааны төрөл, ажиллагчдын тоо**



**Ажиллагчдын тоо**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

**Борлуулалтын орлого:** Мөн дээрх хуульд заасан борлуулалтын орлогын шалгуур үзүүлэлтэд үндэслэвэл судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн 71% нь жилд 300 сая хүртэлх төгрөгийн борлуулалтын орлоготой буюу “бичил” бизнес эрхлэгчид байна. 300 сая төгрөгөөс 1 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой буюу “жижиг” бизнес эрхлэгч нийт оролцогчдын 15%-ийг эзэлж байгаа бол 1-2.5 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой буюу “дунд” бизнес эрхлэгч нийт оролцогчдын 6%-ийг эзэлж байна. Харин 5% нь 2.5 тэрбум төгрөгөөс дээш орлоготой буюу “том” бизнес эрхлэгчид бүрдүүллээ /Дүрслэл 1.4/.

**Дүрслэл 1.4 | Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн жилийн нийт орлого**




Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

ААН-үүдийн борлуулалтын орлогыг аймгуудаар ангилан харвал /Дүрслэл 1.5/ Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорнод, Хэнтий аймгуудад 10 хүртэлх сая төгрөгийн

борлуулалтын орлоготой ААН-үүд, Дархан-Уул, Дундговь, Завхан, Хөвсгөл зэрэг аймгуудад 50-иас дээш сая төгрөгийн борлуулалтын орлоготой ААН-үүд түүвэр судалгаанд түлхүү хамрагджээ.

**Дүрслэл 1.5 | Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн орлого, аймгуудаар**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)


**Хэмжээний ангилал:** Дээр дурдсанчлан ААН-үүдийг ангилахдаа ажилчдын тоо болон борлуулалтын орлогыг нэгэн зэрэг авч үзэх нь зарим ААН-үүд аль ч ангилалд багтахгүй байх асуудал үүсэх тул тус судалгаанд “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих” тухай хуульд заасан тодорхойлолтийн дагуу харгалзах ажилчдын тоогоор авч ААН-үүдийг бичил, жижиг, дунд болон том гэсэн 4 ангилалд авч үзлээ. Үүнд:

- 10 хүртэл ажилтантай, 300 сая төгрөг хүртэл борлуулалтын орлоготой ААН-ийг “Бичил”,
- 10-50 хүртэл ажилтантай, 300 сая төгрөгөөс 1.0 тэрбум төгрөгийн орлоготой ААН-ийг “Жижиг”,
- 50-200 хүртэл ажилтантай 1.0 тэрбум төгрөгөөс 2.5 тэрбум төгрөгийн орлоготой ААН-ийг “Дунд”,

- 200-с дээш ажилтантай 2.5 тэрбум төгрөгөөс дээш орлоготой ААН-ийг “Том” гэж ангиллаа.

Дүрслэл 1.6-д бизнесийн үйл ажиллагааны төрлийг салбарын ангиллаар харууллаа. Үүнд бичил болон жижиг, дунд ангиллуудад бизнесийн үйл ажиллагааны чиглэлүүд харьцангуй төстэй буюу дотоод худалдаа болон үйлчилгээний салбарууд голлох хэсгийг бүрдүүлж байна. Харин том ААН-үүдэд худалдаа, үйлчилгээнээс гадна үйлдвэрлэл болон барилгын салбарын аж ахуйн нэгжүүд голлох хувийг эзэлж байна.

**Дүрслэл 1.6 | Аж ахуйн нэгжийн хэмжээний ангилал, салбараар**





Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

# БИЗНЕСИЙН ОРЧИН

2021 оны судалгаагаар бизнесийн орчны ерөнхий индекс **-0.28** буюу бизнесийн орчин “муу” байна гэсэн үр дүнтэй гарлаа. Энэ нь 2020 оны судалгааны үр дүнгээс бага зэргийн сайжирсан үзүүлэлт болж байгаа хэдий ч үнэлгээний хувьд “муу” түвшинд хэвээр байна.

## БҮЛЭГ 1

Ерөнхий мэдээлэл



## БҮЛЭГ 2

Бизнесийн орчин

- **Макро эдийн засгийн орчин:** Инфляц, валютын ханш хамгийн хүндрэл учруулдаг хүчин зүйлс болж байгаа бөгөөд судалгаанд оролцогчид бизнес эрхлэх эдийн засгийн таатай орчин хангалттай бүрдээгүй гэж үзэж байна.
- **Нийгэм, улс төрийн байдал:** Ядуурал, ажилгүйдэл хамгийн хүндрэл учруулдаг хүчин зүйлс болж байна. Энэ нь дотоод худалдаа болон барилгын салбарын аж ахуйн нэгжүүдэд илүүтэй мэдрэгдэж байна.
- **Хууль, эрх зүй, төрийн зохицуулалт:** Төрийн байгууллагын үйлчилгээ болон хуулийн хэрэгжилтийн индексийн утга өнгөрсөн жилийн үр дүнгээс хамгийн ихээр сайжирлаа.
- **Зах зээлийн орчин:** Тус орчны үзүүлэлтээс иргэдийн худалдан авах чадварын үзүүлэлт хамгийн муу утгатай гарлаа.
- **Дэд бүтцийн хөгжил:** Мэдээлэл холбоо, цахилгаан түгээлт, усан хангамжийн үзүүлэлт бүлгийн индекс эерэг гарахад голлон нөлөөлөв.
- **Санхүүжилтийн орчин:** Зээлийн хүү, барьцаа хөрөнгийн үнэлгээ, зээлийн шимтгэлийн хүчин зүйлс хүндрэл учруулсан хэвээр байна.
- **Дотоод үйл ажиллагаа:** Ур чадвартай ажиллах хүчний нийлүүлэлт хомс байгаа нь бизнесийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөтэй хүчин зүйлс болж байна.

## БҮЛЭГ 3

Бизнесийн үйл ажиллагаа


## БҮЛЭГ 4

Санхүүжилт, дэмжлэг

## БҮЛЭГ 5

Цар тахал, ЗГ-ын төсөл хөтөлбөрийн нөлөө

Аймаг, дүүргээр авч үзвэл Багахангай дүүрэг, Баян-Өлгий, Өвөрхангай болон Өмнөговь аймгуудад бизнесийн орчин харьцангуй боломжийн байгаа бол Увс, Сүхбаатар, Завхан, Хөвсгөл болон Сонгинохайрхан дүүргүүдэд бизнесийн орчин муу байна гэсэн үнэлгээг өгчээ.



## 2. БИЗНЕСИЙН ОРЧИН


**Нэгдсэн дүн:** Энэхүү судалгаагаар бизнес эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйлсийг дараах үндсэн 7 бүлэгт хувааж, бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөгч 41 төрлийн дэд үзүүлэлт, хүчин зүйлсийг тодорхойлж, бүлэг тус бүрийн индексийн утгыг дундажлах замаар бизнесийн орчны ерөнхий индексийг тооцлоо.

- ⇒ Макро эдийн засгийн орчин
- ⇒ Нийгэм, улс төрийн байдал
- ⇒ Хууль, эрх зүй, төрийн зохицуулалт
- ⇒ Зах зээлийн орчин
- ⇒ Дэд бүтцийн хөгжил
- ⇒ Санхүүжилтийн орчин
- ⇒ Дотоод үйл ажиллагаа

2021 оны тус судалгааны үр дүнгээр бизнесийн орчны ерөнхий индекс **-0.28** буюу бизнес эрхлэгчдэд бизнесийн орчин муугаар нөлөөлж байна гэсэн ерөнхий үнэлгээг судалгаанд оролцогчид өглөө. 2020 оны судалгааны үр дүнгээс бизнесийн орчны ерөнхий индексийн утга сайжирсан буюу сөрөг нөлөөлөл буурсан үр дүнтэй гарлаа. Индексийн үзүүлэлтийг МҮХАҮТ-аас жил бүр зохион байгуулдаг “Бизнесийн итгэлийн индекс” тайланд тусгагдсан бизнесийн орчны өөрчлөлтийн үнэлгээний үзүүлэлттэй харьцуулж Дүрслэл 2.1-т харууллаа.

### Дүрслэл 2.1 | Бизнесийн орчны ерөнхий индекс

-2=маш муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маш сайн




Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021), МҮХАҮТ\*

Бизнесийн орчны ерөнхий индексийг бүлэг тус бүрээр харвал нийгэм, улс төрийн байдал, санхүүжилтийн орчин, макро эдийн засгийн орчин болон хууль, эрх зүй, төрийн зохицуулалт гэсэн бүлгийн индексийн утга хамгийн бага буюу бизнесийн үйл ажиллагаанд хамгийн хүндрэл учруулдаг бүлэг болж байна. Харин дэд бүтцийн хөгжил, байгууллагын дотоод хүчин зүйлсийн хувьд харьцангуй боломжийн буюу бизнесийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө багатай байна гэсэн үр дүн гарлаа. Зах зээлийн орчин болон дэд бүтцийн хөгжлийн бүлгийн индекс өнгөрсөн жилийн үр дүнгээс хамгийн ихээр сайжирсан бол дотоод хүчин зүйлс бүлгийн индексийн утга буурсан үзүүлэлттэй байна.

### Дүрслэл 2.2 | Бизнесийн орчны ерөнхий индекс, бүлэг тус бүрээр

-2=маш муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маш сайн



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)


## 2.1 Макро эдийн засгийн орчин

КОВИД-19 цар тахлын улмаас 2020 оны дийлэнх хугацаанд өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдалд шилжин хөл хорио тогтоосон нь үйлчилгээ, дотоод худалдаа болон барилгын салбарын үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлж эдийн засаг 4.6 хувиар агшсан үзүүлэлттэй байв. Харин суурь үеийн нөлөө, эдийн засгийг сэргээх, өрхийн орлогыг дэмжих бодлого, зохицуулалтын арга хэмжээнүүд авч хэрэгжүүлсэн, хөл хорионы дэглэм шат дараатай суларснаар 2021 оны эхний 3 дугаар улирлын байдлаар эдийн засаг 3.6 хувийн өсөлттэй гарлаа /Дүрслэл 2.3/.

Макро эдийн засгийн орчны зүгээс бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд үзүүлж буй нөлөө 2012 оноос хойш тасралтгүй муудаж ирсэн. Харин 2018 оны судалгаагаар макро эдийн засгийн орчны үзүүлж буй сөрөг нөлөөлөл буурсан дүнтэй гарсан хэдий ч дээр дурдсан шалтгаануудын улмаас сөрөг нөлөөлөл 2020 онд эргээд нэмэгдсэн байна. Энэ удаагийн буюу 2021 оны судалгааны үр дүнгээр макро эдийн засгийн орчны зүгээс бизнес эрхлэгчдэд үзүүлж буй нөлөө “муу” буюу индексийн утга **-0.51** утгатай гарлаа. Энэ нь өнгөрсөн оны судалгааны үр дүнгээс сайжирсан үзүүлэлт болж байна /Дүрслэл 2.3/.

### Дүрслэл 2.3 | Макро эдийн засгийн орчин

-2=маш муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маш сайн




Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021), УСХ

Макро эдийн засгийн орчны гол үзүүлэлтүүдээс бизнес эрхлэгчдэд хамгийн ихээр хүндрэл учруулдаг үзүүлэлтээр инфляц, гадаад валютын ханш (юанийн ханш), эдийн засгийн өсөлт болж байна. Эдгээр үзүүлэлтийг өнгөрсөн оны судалгааны үр дүнтэй харьцуулахад гадаадын шууд хөрөнгө оруулалт болон гадаад өр, гадаад валютын ханшийн индексийн утгын сөрөг нөлөө буурсан бол инфляцын индексийн утга сөрөг утга нэмэгдсэн байна. Өөрөөр хэлбэл инфляцаас бусад үзүүлэлтийн сөрөг нөлөөлөл буурсан дүр зурагтай байна. Цар тахал болон инфляцын сөрөг нөлөөг бууруулах зорилгоор Монголбанкны зүгээс авч хэрэгжүүлсэн голлох арга хэмжээнүүдийн тоймыг Шигтгээ 1-т харууллаа.

### Дүрслэл 2.4 | Макро эдийн засгийн орчин, үзүүлэлтээр

-2=маш муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маш сайн



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

### Шигтгээ 1: Цар тахлын үед Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд:

1. Бодлогын хүүг 6 хувь болгож, 5 нэгж хувиар бууруулав.
2. Ажлын байрыг дэмжих жилийн 3 хувийн хүүтэй, 3 хүртэл жилийн хугацаатай зээлийн эх үүсвэр олгож эхлэв.
3. Уул уурхайн бус экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор репо санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгож, банкуудаар дамжуулан олгож байна.




4. Ипотекийн зээлийн хүүг 6 хувь болгон бууруулж, хөтөлбөрийн эх үүсвэрийг жилийн 1.0 их наяд төгрөг байхаар нэмэгдүүлэв.
5. Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийн эргэн төлөлтийг 2021 оныг дуустал хугацаагаар сунгав.
6. Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журамд түр хугацааны өөрчлөлт оруулж, эрсдэлд өртсөн зээлд бүтцийн өөрчлөлт хийв.
7. Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний шимтгэлийг буурууллаа.
8. Эргэн төлөлт нь хүндрэлд орсон зээлдэгчийн хэрэглээний зээлийн хугацааг сунгав.

Эх сурвалж: Монголбанк

Бизнес эрхлэгчдэд нөлөөлж буй макро эдийн засгийн хүчин зүйлсийг салбараар харьцуулбал аж үйлдвэрийн салбарт харьцангуй бага хүндрэл учруулдаг бөгөөд ХАА, дотоод худалдаа болон үйлчилгээний салбарт илүү хүндрэлтэй байна. Бүх салбарын хувьд өмнөх жилийн судалгааны дүнгээс сайжирсан төлөвтэй байна.

#### Дүрслэл 2.5 | Макро эдийн засгийн орчин, салбараар

-2=маши муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маши сайн




Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

ААН-үүдийн хэмжээгээр ангилсан ангиллын хувьд бичил ангилалд хамаарах аж ахуйн нэгжүүдийн хувьд макро эдийн засгийн зүгээс буюу үнэ, гадаад валютын ханш хамгийн ихээр сөрөг нөлөө үзүүлдэг байна. Бусад ангилалд хамаарах аж ахуйн нэгжүүдийн хувьд макро эдийн засгийн орчин харьцангуй багаар сөрөг нөлөө үзүүлдэг байна. Бүх төрлийн аж ахуйн нэгжүүдийн хувьд өмнөх оны судалгааны үр дүнгээс сайжирсан дүр зурагтай байна.


#### Дүрслэл 2.6 | Макро эдийн засгийн орчин, ААН-ийн хэмжээгээр

-2=маши муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маши сайн



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд үйл ажиллагаа эрхэлж буй байршлаас шалтгаалан ямар нөлөө үзүүлдэг болохыг Дүрслэл 2.7-т харууллаа. Увс, Сонгинохайрхан, Дархан-Уул, Сүхбаатар аймаг, дүүргүүдэд бизнес эрхлэгчид хамгийн муу үнэлгээг өгсөн буюу бизнесийн үйл ажиллагаанд нь макро эдийн засгийн зүгээс хамгийн ихээр хүндрэл учруулдаг гэсэн үнэлгээг өгчээ. Харин Баян-Өлгий, Багахангай, Багануур, Архангай аймаг, дүүргүүдэд бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд макро эдийн засгийн үзүүлэлтүүд хүндрэл учруулах нь харьцангуй бага байдаг буюу боломжийн үнэлгээг өглөө.




Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

## 2.2 Нийгэм, улс төрийн байдал

Бизнес эрхлэгчдэд нийгэм, улс төрийн зүгээс үзүүлж буй сөрөг нөлөөлөл 2011 оноос хойш 2018 он хүртэл тасралтгүй буурч ирсэн хэдий ч судалгаа явуулсан нийт хугацааны туршид индексийн утга -1 орчимд буюу “муу” нөлөөлөл үзүүлж байна гэсэн мужид хэвээр байна. Өнгөрсөн жилийн судалгааны үр дүнгээр өмнөх жилүүдийн дундаж утгын ойролцоо түвшинд ирсэн бол энэ жилийн судалгаагаар **-0.67** буюу сөрөг нөлөөлөл буурсан үзүүлэлттэй гарлаа.

Дүрслэл 2.8 | Нийгэм, улс төрийн байдал

-2=маш муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маш сайн




Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021), Transparency International

Судалгааны үр дүнгээс харахад бизнес эрхлэгчдэд нийгмийн орчны зүгээс ядуурал, ажилгүйдэл болон хээл, хахууль хамгийн их хүндрэл учруулдаг хүчин зүйлс болж байна. Энэхүү үр дүнг өнгөрсөн жилийн судалгааны үр дүнтэй харьцуулахад бүх үзүүлэлтийн индексийн утга сайжирсан буюу сөрөг нөлөөлөл буурсан дүр зурагтай байна.

Дээр дурдсанчлан авилга, хээл хахууль нь бизнесийн орчинд ихээхэн сөрөг нөлөө үзүүлдэгтэй холбогдуулан судалгааны үр дүнг Transparency International байгууллагаас гаргадаг Авилгын индекс /Corruption perceptions index/-ийн үзүүлэлттэй харьцууллаа /Дүрслэл 2.8/. Тус индексийн 2020 оны үзүүлэлтээр Монгол Улс 35 оноотойгоор дэлхийн 180 орноос 111-т эрэмбэлэгдэж байгаа нь 2019 оны судалгааны үр дүнгээс 5 байраар ухарсан үзүүлэлт болж байгаа бөгөөд тус түүвэр судалгааны индексийн утгын хандлагатай нийцтэй байна гэж ажиглагдлаа.

### Дүрслэл 2.9 | Нийгэм, улс төрийн байдал, үзүүлэлтээр


-2=маши муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маши сайн



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

### Шигтгээ 2: Хүний хөгжлийн индекс (Human development index (HDI))

Хүний хөгжлийн индекс (ХХИ) нь хүний амьдралын чанарыг харуулдаг үзүүлэлт бөгөөд эрүүл байж урт удаан наслах, боловсрол эзэмших, амьжиргааны зохистой нөхцөлд аж төрөх гэсэн үндсэн гурван хэмжигдэхүүнээр илэрхийлэгддэг. НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр (UNDP)-ийн хийсэн 2019 оны судалгаагаар Монгол Улсын ХХИ 0.74 буюу дэлхийн 190 орчим орноос 99-т эрэмбэлэгдэж, “Хүний хөгжил өндөртэй (High human development)” ангилалд багтаж байна. Энэ нь 2018 оноос 7 байраар ухарсан хэдий ч тус ангилалдаа хэвээр хадгалагдсаар байна.




Эх сурвалж: UNDP

Нийгэм, улс төрийн орчны хүчин зүйлс нь ерөнхий салбарын хувьд дотоод худалдаа

болон үйлчилгээний салбарт хамгийн их сөрөг нөлөөлөл үзүүлдэг бол аж үйлдвэр, ХАА болон барилгын салбарт харьцангуй бага сөрөг нөлөө үзүүлдэг гэж судалгаанд оролцогчид үзжээ. Өмнөх жилийн үр дүнгээс барилга болон аж үйлдвэрийн салбарт үзүүлэх сөрөг нөлөө буурсан байна.

### Дүрслэл 2.10 | Нийгэм, улс төрийн байдал, үзүүлэлтээр

-2=маши муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маши сайн




Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Бичил ангилалд хамаарах аж ахуйн нэгжүүдийн хувьд нийгмийн орчны хүчин зүйлс хамгийн хүндрэлтэй байдаг бол том ангилалд хамаарах аж ахуйн нэгжүүдийн хувьд харьцангуй бага нөлөөтэй байна. Өмнөх жилийн судалгааны үр дүнгээр дунд ангилалд хамаарах аж ахуйн нэгжүүдийн хувьд хамгийн хүндрэлтэй байсан бол энэ жилийн тухайд сөрөг нөлөө буурсан үзүүлэлттэй байна.

### Дүрслэл 2.11 | Нийгэм, улс төрийн байдал, ААН-ийн хэмжээгээр

-2=маши муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маши сайн




Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Нийгэм, улс төрийн байдал нь орон нутаг, дүүргүүдэд үйл ажиллагаа эрхэлж буй бизнес эрхлэгчдэд хэрхэн нөлөөлдөг болохыг Дүрслэл 2.12-т харууллаа. Тус үзүүлэлт нь Сүхбаатар, Увс, Ховд болон Булган аймгуудад үйл ажиллагаа явуулдаг

бизнес эрхлэгчдэд хамгийн муу нөлөө үзүүлдэг бол Багахангай, Баян-Өлгий, Багануур, Өвөрхангай аймаг, дүүргүүдэд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд харьцангуй бага хүндрэл учруулдаг байна.

Дүрслэл 2.12 | Нийгэм улс төрийн байдал, аймаг болон дүүргээр



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

### 2.3 Хууль, эрх зүй, төрийн зохицуулалтын орчин

Энэхүү судалгаанд хууль, эрх зүй, төрийн зохицуулалтын зүгээс бизнесийн үйл ажиллагаанд саад болж буй хүчин зүйлсийг газар эзэмших боломж, гадаад худалдаа хийх нөхцөл, татварын тогтолцоо, хуулийн хэрэгжилт, төрийн байгууллагын үйлчилгээ болон хяналт, шалгалтын тогтолцоо гэсэн зургаан үзүүлэлтээр төлөөлүүлэн, чанарын хариултыг тоон утгад шилжүүлэх замаар бүлгийн индексийг тооцож гаргалаа.


Энэ жилийн түүвэр судалгааны үр дүнгээр хууль, эрх зүй, төрийн зохицуулалтын орчны ерөнхий индекс **-0.39** буюу хууль, эрх зүй, төрийн зохицуулалтын орчны зүгээс бизнес эрхлэх таатай орчин хангалттай бүрдээгүй байна гэсэн үнэлгээг

судалгаанд оролцогчид өглөө. Гэсэн хэдий ч энэхүү үзүүлэлт нь өмнөх жилийн судалгааны үр дүнгээс нэлээдгүй сайжирсан үзүүлэлт болж байна /Дүрслэл 2.13/.

Дэлхийн банкнаас боловсруулж гаргадаг бизнесийн үйл ажиллагааны хуулийн болон бусад зохицуулалт, тэдгээрийн хэрэгжилтийг харуулдаг “Doing business” индикатор үзүүлэлтээр Монгол Улс 2020 оны байдлаар 67.8 оноотойгоор 190 орноос 81-т жагсаж байна. Энэ нь 2019 оноос 7 байраар ухарсан үзүүлэлт болж байгаа бөгөөд 2016 онд хамгийн өндөр буюу 56-д эрэмбэлэгдэж байжээ. Үүнийг хууль эрх зүйн зохицуулалтын бүлгийн индексийн үзүүлэлттэй харьцуулж Дүрслэл 2.13-т харууллаа.

### Дүрслэл 2.13 | Хууль, эрх зүй, төрийн зохицуулалт

-2=маш муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маш сайн



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021), Дэлхийн банк

2021 оны судалгааны үр дүнгээс харахад бизнес эрхлэгчдэд хууль, эрх зүй, төрийн зохицуулалтын зүгээс хамгийн их хүндрэл учруулдаг гэж үнэлэгдсэн үзүүлэлт нь газар эзэмших боломж, гадаад худалдаа хийх нөхцөл, татварын тогтолцоо гэсэн үзүүлэлтүүд болж байна. Өнгөрсөн жилийн судалгааны үр дүнгээр хуулийн хэрэгжилт, төрийн байгууллагын үйлчилгээ хамгийн бага буюу муу индексийн утгатай байсан бол энэ жилийн судалгаанд индексийн утга нь хамгийн ихээр сайжирсан үзүүлэлттэй байна. Энэ нь засгийн газраас авч хэрэгжүүлсэн төрийн үйлчилгээний шинэчлэлтийн ажлуудтай холбоотой байж болзошгүй юм /Шигтгээ 3/.

### Дүрслэл 2.14 | Хууль, эрх зүй, төрийн зохицуулалт, үзүүлэлтээр

-2=маш муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маш сайн



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

### Шигтгээ 3: Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем "e-Mongolia"-ийн тухай

2020 оны аравдугаар сарын 01-нд олон нийтэд танилцуулагдсан бөгөөд өнгөрсөн 1 жилийн хугацаанд 57 төрийн байгууллагын 571 төрлийн үйлчилгээг цахимжуулж, 4.9 сая удаагийн төрийн үйлчилгээг амжилттай үзүүлж, төлбөртэй үйлчилгээнээс 4.8 тэрбум төгрөгийг улсын төсөв төвлөрүүлээд байна.


Систем нэвтэрснээр Монгол улсын иргэн төрийн үйлчилгээ авахдаа үйлчилгээ үзүүлэгч байгууллагуруу ирж, буцах унааны зардал, хугацаанаас үүдэлтэй зардал (хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр), төрийн үйлчилгээ авахад шаардагдах баримт бичиг бүрдүүлэх зардал зэрэгт нийт 52.8 тэрбум төгрөг хэмнэгдээд байна.

Эх сурвалж: Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар

Хууль эрх зүйн орчны хүчин зүйлсийг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл дотоод худалдаа, үйлчилгээ болон барилгын салбарт хамгийн их сөрөг нөлөөлөл үзүүлдэг бол аж үйлдвэр, ХАА-н салбарт харьцангуй бага сөрөг нөлөө үзүүлдэг гэж судалгаанд оролцогчид үзжээ.

### Дүрслэл 2.15 | Хууль, эрх зүй, төрийн зохицуулалт, салбараар

-2=маш муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маш сайн




Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Бичил ангилалд хамаарах аж ахуйн нэгжүүдийн хувьд хууль эрх зүйн орчны хүчин зүйлс хамгийн хүндрэлтэй байдаг бол дунд ангилалд хамаарах аж ахуйн нэгжүүдийн хувьд харьцангуй бага нөлөөтэй байна. Өмнөх жил дунд ангилалд хамаарах аж ахуйн нэгжүүдийн хувьд хамгийн хүндрэлтэй байсан бол энэ жилийн тухайд сөрөг нөлөө хамгийн ихээр буурчээ.


**Дүрслэл 2.16 | Хууль, эрх зүй, төрийн зохицуулалт, ААН-ийн хэмжээгээр**

-2=маш муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маш сайн



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

**Дүрслэл 2.17 | Хууль, эрх зүй, төрийн зохицуулалт, аймаг болон дүүргээр**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)




## 2.4 Зах зээлийн орчин

Монголбанкнаас зохион байгуулдаг тус судалгаанд зах зээлийн орчны зүгээс бизнесийн үйл ажиллагаанд саад болж буй хүчин зүйлсийг хэрэглэгчдийн худалдан авах чадвар, зах зээлийн багтаамж, зах зээлийн өрсөлдөөн, мэдээллийн хүртээмж болон технологийн дэвшил гэсэн таван үзүүлэлтээр төлөөлүүлэн, чанарын хариултыг тоон утгад шилжүүлэн тооцож зах зээлийн орчны бүлгийн индексийг гаргалаа.

Бизнес эрхлэгчдэд зах зээлийн орчны зүгээс үзүүлж буй нөлөө 2015 болон 2016 онуудад хамгийн их сөрөг нөлөөтэй буюу индексийн утга хамгийн бага байжээ. Харин 2018 оны судалгааны дүнгээр нэлээдгүй сайжирсан ч 2020 онд нэлээд муудсан байна. Энэ жилийн судалгааны үр дүнгээр **-0.01** буюу өнгөрсөн жилээс нэлээдгүй сайжирсан үзүүлэлттэй гарсан нь индексийн утгын хувьд түүхэн хамгийн өндөр утга болж байна.

### Дүрслэл 2.18 | Зах зээлийн орчин

-2=маш муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маш сайн



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)


Зах зээлийн орчны зүгээс иргэдийн худалдан авах чадвар хамгийн муу буюу бизнес эрхлэгчдэд сөрөг нөлөө үзүүлж байгаа бол технологийн дэвшил, мэдээллийн хүртээмж, зах зээлийн өрсөлдөөний үзүүлэлтүүд эерэг нөлөө

үзүүлж байна. Өнгөрсөн жилийн судалгааны үр дүнгээс мэдээллийн хүртээмж, зах зээлийн өрсөлдөөн болон технологийн дэвшил гэсэн үзүүлэлтүүдийн индексийн утга нэлээдгүй сайжирсан байна.

Худалдан авах чадварыг төлөөлүүлэн Монгол Улсын 1 хүнд ногдох Үндэсний нийт орлогын<sup>1</sup> үзүүлэлтийг авч үзэхэд 2020 онд 3,670 ам.доллар буюу “Дунджаас бага орлоготой” орны ангилалд багтаж байна. Энэ нь өмнөх оноос 3.2 хувиар буурсан үзүүлэлт болж байгаа бөгөөд дэлхийн 190 орчим орноос 116-д эрэмбэлэгдэж байна /Дүрслэл 2.18/. Дээрх дүрслэлээс харахад судалгааны үр дүн нь статистик тоон мэдээлэлтэй нийцтэй байдал ажиглагдаж байна.

### Дүрслэл 2.19 | Зах зээлийн орчин, үзүүлэлтээр

-2=маш муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маш сайн



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Статистик, мэдээллээс харахад өрхийн баланс 2021 онд цалингийн бус (тэтгэвэр, тэтгэмж) орлого нэмэгдсэнтэй холбоотойгоор эерэг утгатай болсон буюу худалдан авах чадвар сайжирсан дүр зурагтай байгаа хэдий ч цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан өрхүүдийн хэрэглээнд өөрчлөлт бага гарчээ. Өөрөөр хэлбэл, өрхүүд орлого нэмэгдсэний хэрээр хэрэглээндээ зарцуулахаас илүү хадгалах хандлагатай болсон нь судалгаанд


<sup>1</sup> Дэлхийн банкны Атласын аргаар тооцсон үзүүлэлт

оролцогч ААН-үүдийн зүгээс иргэдийн худалдан авах чадвар буурсан гэж үзэхэд хүргэсэн байж болзошгүй юм /Шигтгээ 4/.


#### Шигтгээ 4: Өрхийн дундаж орлого, зардлын болон хадгаламжийн үзүүлэлт

Нэг өрхийн сарын дундаж орлого, зардлын үзүүлэлт 2021 оны III улирлын байдлаар харгалзан 1,636; 1,495 сая төгрөг байгаа бөгөөд өрхийн баланс 141.7 мянган төгрөг болж байна. Энэхүү үзүүлэлтээр 2015 оны III улирлаас хойш анх удаа өрхийн баланс эерэг болж, сүүлийн 2 улирал дараалан эерэг утгатай гарлаа.

2021 оны эхний 2 улирлын өрхийн дундаж орлогын өсөлтийг тэтгэвэр, тэтгэмжийн өсөлт тайлбарлаж байгаа бол 2021 оны III улирлын өсөлтийг цалин, хөлсний өсөлт тайлбарлаж байна. Харин өрхийн дундаж зардал 2020 оны IV улиралд 4.9 хувиар буурсан бөгөөд үүнийг мөнгөн зарлага түүний дотор хүнсний болон хүнсний бус зардлын төрөл голлон тайлбарлаж байна.



#### Өрхийн орлогын улирлын өөрчлөлт, бүрэлдэхүүн хэсгээр



#### Өрхийн зардлын улирлын өөрчлөлт, бүрэлдэхүүн хэсгээр



Иргэдийн төгрөгийн хадгаламжийн үлдэгдэл 2019 оны эцэст 9.3 их наяд төгрөг байсан бол үүнээс хойш улирал бүр өссөөр 2021 оны III улирлын байдлаар 13.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 28%-иар өсөөд байна.


#### Иргэдийн төгрөгийн хадгаламжийн үлдэгдэл



Эх сурвалж: УСХ, Монголбанк

Зах зээлийн орчны хүчин зүйлсийг эдийн засгийн үйл ажиллагааны ерөнхий салбарын хувьд авч үзвэл үйлчилгээ болон дотоод худалдааны салбарт бага зэргийн сөрөг нөлөөтэй, ХАА-н салбарын хувьд нөлөөгүй байгаа бол барилга болон аж үйлдвэрийн салбарт эерэгээр нөлөөлсөн үр дүнтэй байна. Салбар тус бүрийн хувьд индексийн утга сайжирсан буюу сөрөг нөлөө буурч барилга, аж үйлдвэрийн салбарт эерэгээр нөлөө үзүүлсэн байна. Үүнд орон сууцны хөтөлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлэх замаар барилгын салбарыг дэмжсэн, аж үйлдвэрийн салбарт хөл хорионы нөлөө бага байсан зэрэг нь нөлөөлсөн байх талтай.


**Дүрслэл 2.20 | Зах зээлийн орчин, салбараар**  
 -2= маш муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маш сайн



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Аж ахуйн нэгжийн хэмжээний хувьд бүлгийн индексийн үзүүлэлтийг харьцуулж харвал бичил ангилалд бага зэргийн сөрөг нөлөөтэй байгаа бол бусад ангиллын хувьд эерэг нөлөөтэй байна. Өмнөх жилийн үзүүлэлтээс дунд, том ангиллын аж ахуйн нэгжүүдийн хувьд хамгийн ихээр сайжирсан үзүүлэлтийг үзүүлээ.


**Дүрслэл 2.21 | Зах зээлийн орчин, ААН-ийн хэмжээгээр**  
 -2= маш муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маш сайн



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Зах зээлийн орчны зүгээс Говьсүмбэр, Завхан, Увс болон Баянхонгор аймагт бизнес эрхлэгчдэд үзүүлж буй нөлөөлөл хамгийн их сөрөг байгаа бол Багахангай дүүрэг, Өвөрхангай, Өмнөговь болон Баян-Өлгий аймгуудад илүү эерэг нөлөөтэй байна.

**Дүрслэл 2.22 | Зах зээлийн орчин, аймаг болон дүүргээр**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

## 2.5 Дэд бүтцийн хөгжил


Энэхүү судалгаанд дэд бүтцийн хөгжлийн зүгээс бизнесийн үйл ажиллагаанд саад болж буй хүчин зүйлсийг тээвэрлэлт, зам, дулааны шугам сүлжээ, усан хангамж, цахилгаан түгээлт болон мэдээлэл холбоо

гэсэн зургаан төрлийн үзүүлэлтээр төлөөлүүлэн, чанарын хариултыг тоон утгад шилжүүлэх замаар бүлгийн индексийг тооцож гаргалаа.

Энэ жилийн түүвэр судалгааны үр дүнгээр дэд бүтцийн хөгжлийн ерөнхий индекс - **0.15** буюу дэд бүтцийн хөгжлийн байдал бизнес эрхлэгчдэд бага зэргийн эерэг нөлөөтэй байна гэсэн үнэлгээг судалгаанд оролцогчид өглөө. Энэ нь өмнөх судалгаануудтай харьцуулахад анх удаа эерэг утгатай гарсан үзүүлэлт болж байна /Дүрслэл 2.23/. Үүнд Засгийн газрын зүгээс төмөр зам, автозамын чиглэлд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдтэй холбоотой байж болох юм /Шигтгээ 5/. Түүнчлэн цар тахлын үеийн хөл хориотой холбоотой 2020 онд буурсан ачаа тээвэрлэлт 2021 онд эргэн сэргэсэн нь нөлөөлсөн байх талтай. Тухайлбал, ҮСХ-ны тээсэн ачааны статистик мэдээллээр 2020 онд 30,455 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 25%-иар буурсан үзүүлэлт болж байна. 2021 оны III улирлын байдлаар тус үзүүлэлт өмнөх оны мөн үеэс 2 дахин өсч 35,589 мянган тоннд хүрсэн байна /Дүрслэл 2.23/.

#### Дүрслэл 2.23 | Дэд бүтцийн хөгжил

-2=маш муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маш сайн



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021), ҮСХ

Судалгааны үр дүнгээс харахад бизнес эрхлэгчдэд дэд бүтцийн хөгжлийн зүгээс хамгийн их хүндрэл учруулдаг гэж үнэлэгдсэн тээвэрлэлт болон зам гэсэн үзүүлэлтүүд болж байгаа бол мэдээлэл холбоо, цахилгаан түгээлт, усан хангамж болон дулааны шугам сүлжээний үзүүлэлт сайнаар нөлөөлдөг үзүүлэлт болж байна. 2020 оны судалгааны үр дүнгээр зам, дулааны шугам сүлжээний индексийн утга

сөрөг буюу муугаар нөлөөлдөг байсан бол энэ жил эерэг утгатай болж сайжирчээ.

#### Дүрслэл 2.24 | Дэд бүтцийн хөгжил, үзүүлэлтээр

-2=маш муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маш сайн



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

#### Шигтгээ 5: Дэд бүтцийн талаарх зарим мэдээлэл

**Шинэ төмөр зам төсөл:** УИХ-ын 2010 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д Монгол Улсад шинээр баригдах 6,600 орчим км төмөр замыг 3 үе шаттайгаар барьж байгуулахаар зааж өгсөн. Уг тогтоол болон Засгийн газрын бусад тогтоолуудын дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг Тавантолгойн уурхайгаас Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян баг хүртэлх 416.1 км урт Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам, Өмнөговь аймгийн Гашуунсухайтын хилийн боомт хүртэлх 240 км урт Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлуудыг 2019 онд эхлүүлж, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын гол замыг 2021 оны 05 дугаар сард барьж дуусгасан бөгөөд ажлын гүйцэтгэл 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар 92%-ийн гүйцэтгэлтэй байна. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажил 74%-ийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд 2022 оны

10 дугаар сард ашиглалтад өгөхөөр төлөвлөгдөж байна. Ийнхүү Өмнөговь, Дорноговь аймгийн нутагт нийт 650 орчим км төмөр зам ашиглалтад ороход бэлэн болоод байна.


**Авто зам:** Одоо ашиглагдаж байгаа улсын чанартай хатуу хучилттай авто замын урт 7,551.5 км байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд 2,241.1 км хатуу хучилттай авто замыг барьж ашиглалтад оруулаад байна. Ингэснээр нийт 20 аймгийн төв, 106 сум, 5 хилийн боомт хатуу хучилттай авто замаар Улаанбаатар хоттой холбогдоод байна. 2021 онд 19 чиглэлийн 287.2 км хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

*Эх сурвалж: Зам тээвэр, хөгжлийн яам*

Дэд бүтцийн хөгжлийг тодорхойлох хүчин зүйлсийг эдийн засгийн үйл ажиллагааны ерөнхий салбарын хувьд авч үзвэл аж үйлдвэр болон үйлчилгээний салбарт хамгийн ихээр эерэг нөлөөтэй байдаг бөгөөд өнгөрсөн жилийн үр дүнгээс хамгийн ихээр сайжирсан үзүүлэлт болж байна.

#### Дүрслэл 2.25 | Дэд бүтцийн хөгжил, салбараар

*-2=маш муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маш сайн*



*Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)*

Байгууллагын хэмжээгээр ангилсан ангиллын дагуу бүлгийн индексийг харьцуулж үзвэл дунд, жижиг болон том ангиллын аж ахуйн нэгжүүдэд дэд бүтцийн хөгжил эерэг нөлөөтэй буюу индексийн утга ойролцоо байна. 2020 оны судалгааны үр дүнгээс дунд болон том аж ахуйн нэгжүүдийн үнэлгээ хамгийн ихээр сайжирчээ.

#### Дүрслэл 2.26 | Дэд бүтцийн хөгжил, ААН-ийн хэмжээгээр


*-2=маш муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маш сайн*



*Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)*

Дэд бүтцийн хөгжил бизнес эрхлэхэд үзүүлж буй нөлөөллийг индексийн утгаар тооцоход хамгийн өндөр буюу эерэг нөлөөтэй гэсэн үзүүлэлтээр Говьсүмбэр, Багахангай дүүрэг, Дундговь болон Өмнөговь аймгууд тэргүүлж байна. Харин индексийн утга бага гарсан аймаг, дүүргээр Чингэлтэй дүүрэг, Дорноговь, Сэлэнгэ болон Хэнтий зэрэг аймаг, дүүргүүд болж байна.





Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

## 2.6 Санхүүжилтийн орчин

Банкуудын зээлийн тайлангаар хувийн байгууллагад олгосон нийт зээлийн үлдэгдэл 2021 оны III улирлын байдлаар 9,248 тэрбум төгрөг байгаа нь 2020 оны эцсээс 18%-иар өссөн үзүүлэлт болж байна. 2020 онд хувийн байгууллагад олгосон зээлийн үлдэгдэл 7%-иар буурч байв. Хувийн байгууллагад олгосон нийт зээлийн үлдэгдлийн 27%-ийг дотоод худалдааны салбарт, 17%-ийг барилгын салбарт олгосон зээл байгаа бол уул уурхай, олборлолтын болон боловсруулах үйлдвэрлэлийн салбар тус бүр 16%-ийг бүрдүүлж байна.

Энэхүү судалгаанд санхүүжилтийн орчны зүгээс бизнесийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж буй хүчин зүйлсийг зээлийн хүү, барьцаа хөрөнгийн үнэлгээ, зээлийн шимтгэл, хураамж, зээлийн батлан даалт, зээлийн хэмжээ болон зээлийн хугацаа гэсэн зургаан үзүүлэлтээр төлөөлүүлэн, чанарын хариултыг тоон утгад шилжүүлэх замаар бүлгийн индексийг тооцож гаргалаа.

Түүвэр судалгааны үр дүнгээр санхүүжилтийн орчны ерөнхий индекс - **0.56** буюу санхүүжилтийн орчны зүгээс бизнес эрхлэх таатай орчин хангалттай бүрдээгүй байна гэсэн үнэлгээг судалгаанд оролцогчид өглөө. Хэдий тийм боловч энэхүү үзүүлэлт нь өмнөх жилийн судалгааны үр дүнгээс нэлээдгүй сайжирсан үзүүлэлт болж байгаа бөгөөд өмнөх жилүүдийн судалгааны дунджаас харьцангуй бага байна /Дүрслэл 2.28/.

### Дүрслэл 2.28 | Санхүүжилтийн орчин

-2=маши муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маши сайн



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021), Монголбанк<sup>2</sup>


<sup>2</sup> Хувийн байгууллагад олгосон нийт зээлийн үлдэгдлийн үзүүлэлтийг харьцуулж харуулав.



2021 оны судалгааны үр дүнгээс харахад бизнес эрхлэгчдэд санхүүжилтийн орчны зүгээс хамгийн их хүндрэл учруулдаг гэж үнэлэгдсэн үзүүлэлт нь зээлийн хүү, барьцаа хөрөнгийн үнэлгээ, зээлийн шимтгэл, хураамжийн үзүүлэлтүүд болж байна. Энэ жилийн үр дүнг 2020 оны судалгааны үр дүнтэй харьцуулбал зээлийн хэмжээ, зээлийн хугацаа, зээлийн шимтгэл хураамж гэсэн үзүүлэлтүүдийн индексийн утга хамгийн ихээр сайжирсан үр дүнг харууллаа.

#### Дүрслэл 2.29 | Санхүүжилтийн орчин, үзүүлэлтээр

-2=маш муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маш сайн



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

#### Шигтгээ 6: Урт хугацаат репо арилжааны<sup>3</sup> хөнгөлөлттэй зээлийн тухай


2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн Мөнгөний бодлогын хорооны шийдвэрээр урт хугацаат санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлэх шийдвэр гаргаснаар ЖДҮ эрхлэгч 300 сая, уул уурхайн салбарынханд 1.0 тэрбум хүртэл төгрөгийн зээл авах боломж бүрдэв. Үүнээс хойш 2021 оны 10 дугаар сарын 8-ний өдрийг хүртэл хугацаанд 2,845 зээлдэгчид 731 тэрбум төгрөгийн зээлийг шинээр болон дахин санхүүжүүлэх байдлаар олгоод байна.

Тус хөтөлбөрийн гол зорилго нь ЖДҮ эрхлэгч, уул уурхайн бус экспортлогч ААН-ийг дэмжих бөгөөд жилийн 10.5 хувийн хүүтэй, 2 жилээс доошгүй хугацаатай нөхцөлөөр зээлийг банкуудаар дамжуулан үргэлжлүүлэн олгож байна. Дараах дүрслэлд олгосон зээлийн хэмжээг салбарын ангиллаар, аж ахуйн нэгжийн хэмжээгээр болон байршлаар харууллаа.


#### Олгосон зээл, ерөнхий салбарын ангиллаар



#### Аж ахуйн нэгжийн хэмжээгээр



#### Байршлаар




Эх сурвалж: Монголбанк

<sup>3</sup> Репо арилжаа нь төв банкнаас зөвшөөрсөн активыг барьцаалан банканд санхүүжилт олгох Төв банкны бодлогын хэрэгсэл юм.

Санхүүжилтийн орчны хүчин зүйлсийг эдийн засгийн үйл ажиллагааны ерөнхий салбарын хувьд авч үзвэл ХАА-н салбарт хамгийн ихээр сөрөг нөлөөлөл үзүүлдэг бол аж үйлдвэр болон барилгын салбарт харьцангуй бага сөрөг нөлөө үзүүлдэг гэж судалгаанд оролцогчид үзжээ. Өмнөх жилийн үр дүнгээс аж үйлдвэр, барилгын салбарт хамгийн ихээр сайжирсан үзүүлэлтийг үзүүлсэн байна. Ингэж сайжрахад Монголбанк болон Засгийн газрын зүгээс уул уурхайн бус салбарт авч хэрэгжүүлсэн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрүүд нөлөөлсөн байх магадлалтай юм /Шигтгээ 6/.

**Дүрслэл 2.30 | Санхүүжилтийн орчин, салбараар**  
-2=маш муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маш сайн




Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Байгууллагын хэмжээгээр ангилсан ангиллын дагуу бүлгийн индексийг харьцуулж үзвэл бичил ангилалд хамаарах аж ахуйн нэгжүүдийн хувьд санхүүжилтийн орчны хүчин зүйлс

хамгийн хүндрэлтэй байдаг бол том ангилалд хамаарах аж ахуйн нэгжүүдийн хувьд харьцангуй боломжийн байна гэсэн хариултыг өгчээ. Өмнөх жил дунд, том ангилалд хамаарах аж ахуйн нэгжүүдийн хувьд хамгийн хүндрэлтэй байсан бол энэ жилийн тухайд сөрөг нөлөө хамгийн ихээр буурсан үзүүлэлттэй ангилал болж байна.

**Дүрслэл 2.31 | Санхүүжилтийн орчин, ААН-ийн хэмжээгээр**


-2=маш муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маш сайн



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Санхүүжилтийн орчны зүгээс бизнес эрхлэхэд үзүүлж буй нөлөөллийг индексийн утгаар тооцоход хамгийн өндөр буюу сөрөг нөлөө багатай гэсэн үзүүлэлтээр Өмнөговь, Архангай болон Говь-Алтай аймгууд тэргүүлж байна. Харин индексийн утга багатай буюу сөрөг нөлөө хамгийн өндөртэй аймаг, дүүргээр Увс, Дундговь, Сонгинохайрхан дүүрэг, Хөвсгөл болон Сүхбаатар дүүргүүд болж байна.

Дүрслэл 2.32 | Санхүүжилтийн орчин, аймаг болон дүүргээр



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

## 2.7 Дотоод хүчин зүйлс

Энэхүү судалгаанд байгууллагын дотоод хүчин зүйлсийг ажиллах хүчний нийлүүлэлт, ажиллах хүчний ур чадвар, түүхий эдийн олдоц, бараа, бүтээгдэхүүний борлуулалт, барилга байгууламжийн хүрэлцээ, шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх боломж, тоног төхөөрөмжийн чанар, өрсөлдөх чадвар гэсэн найман үзүүлэлтээр төлөөлүүлэн, чанарын хариултыг тоон утгад шилжүүлэх замаар бүлгийн индексийг тооцож гаргалаа.

Түүвэр судалгааны үр дүнгээр байгууллагын дотоод хүчин зүйлсийн ерөнхий индекс **0.01** буюу дотоод үйл ажиллагааны хүчин зүйлс хангалттай гэсэн үнэлгээг судалгаанд оролцогчид өгчээ. Хэдий тийм боловч энэхүү үзүүлэлт нь өмнөх жилийн судалгааны үр дүнгээс нэлээдгүй муудсан үзүүлэлт болж байгаа бөгөөд өмнөх жилүүдийн судалгааны дунджаас харьцангуй бага байна /Дүрслэл 2.33/.

**Дүрслэл 2.33 | Дотоод хүчин зүйлс**

-2=маш муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маш сайн



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021), УСХ

2021 оны судалгааны үр дүнгээс харахад бизнес эрхлэгчдэд дотоод хүчин зүйлсийн зүгээс хамгийн их хүндрэл учруулдаг гэж үнэлэгдсэн үзүүлэлт нь ажиллах хүчний нийлүүлэлт, түүний ур чадвар болж байна. Энэ нь 2020 оны судалгааны үр дүнгээс нэлээдгүй муудсан үзүүлэлт болж байна. 2020 оны судалгаан үр дүнгээр бүх

үзүүлэлтийн хувьд индексийн утга эерэг утгатай буюу бизнесийн үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлдөг гэсэн үр дүнтэй гарч байсан бол энэ удаад ажиллах хүчний нийлүүлэлт, ажиллах хүчний ур чадвар, түүхий эдийн олдоц, бараа бүтээгдэхүүний борлуулалтын индексийн утгууд сөрөг утгад шилжсэн байна. Ажиллах хүчний үзүүлэлт ийнхүү буурахад халамж нэмэгдсэнтэй холбоотой ажиллах хүчний оролцооны түвшин буурч байгаа нь нөлөөлсөн байж болзошгүй юм. Тухайлбал, ажиллагчид болон ажилгүй хүн амын нийлбэрээр тодорхойлогддог ажиллах хүчний үзүүлэлт 2021 оны III улирлын байдлаар 1,227 мянган хүн байгаа нь 2020 оноос 1.9%-иар буурсан үзүүлэлттэй байна. Тус үзүүлэлт 2019 онд 6.2%-иар, 2020 онд 1.8%-иар тус бүр буурч байжээ (Дүрслэл 2.33).

**Дүрслэл 2.34 | Дотоод хүчин зүйлс, үзүүлэлтээр**

-2=маш муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маш сайн




Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Байгууллагын дотоод хүчин зүйлсийн индексийн үзүүлэлтийг эдийн засгийн үйл ажиллагааны ерөнхий салбарын хувьд авч үзвэл ХАА болон дотоод худалдааны салбарт хамгийн ихээр сөрөг нөлөөтэй байгаа бол аж үйлдвэр болон барилгын салбарт харьцангуй эерэг нөлөөтэй байна гэж судалгаанд оролцогчид үзжээ. Өмнөх

жилийн үр дүнгээс үйлчилгээ болон дотоод худалдааны салбарт хамгийн ихээр муудсан үзүүлэлттэй байна.


**Дүрслэл 2.35 | Дотоод хүчин зүйлс, салбараар**  
-2=маш муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маш сайн



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)  
Байгууллагын хэмжээгээр ангилсан ангиллын дагуу бүлгийн индексийг харьцуулж үзвэл бичил ангилалд хамаарах аж ахуйн нэгжүүдийн хувьд дотоод хүчин зүйлс хамгийн хүндрэлтэй байдаг бол том ангилалд хамаарах аж ахуйн нэгжүүдийн хувьд харьцангуй боломжийн байна гэсэн хариултыг өгчээ. Өмнөх жил дунд, том ангилалд хамаарах аж ахуйн нэгжүүдийн хувьд хамгийн хүндрэлтэй байсан бол энэ


жилийн тухайд сөрөг нөлөө хамгийн ихээр буурсан үзүүлэлт болж байна.

**Дүрслэл 2.36 | Дотоод хүчин зүйлс, ААН-ийн хэмжээгээр**  
-2=маш муу, 1=муу, 0=дунд, +1=сайн, +2=маш сайн



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)  
Дотоод хүчин зүйлсийн зүгээс бизнес эрхлэхэд үзүүлж буй нөлөөллийг индексийн утгаар тооцоход хамгийн өндөр буюу сөрөг нөлөө багатай гэсэн үзүүлэлтээр Багахангай дүүрэг, Өвөрхангай, Говь-Алтай, Өмнөговь болон Багануур дүүргүүд тэргүүлж байна. Харин индексийн утга багатай буюу сөрөг нөлөө хамгийн өндөртэй аймаг, дүүргээр Завхан, Хэнтий, Хөвсгөл болон Архангай аймаг, дүүргүүд болж байна.

**Дүрслэл 2.37 | Дотоод хүчин зүйлс, аймаг болон дүүргээр**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

# БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

## БҮЛЭГ 1

*Ерөнхий  
мэдээлэл*

- **Орлого**

Өнгөрсөн онтой харьцуулахад судалгаанд оролцсон нийт ААН-ийн 58%-д нь борлуулалтын орлого буурсан байна. Аймгуудаар авч үзвэл Завхан, Хөвсгөл, Говьсүмбэр, Увс аймгуудад орлого хамгийн ихээр (нийт ААН-ийн 74-88%-д) буурчээ. Үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл ХАА, худалдаа, үйлчилгээний салбарт, хэмжээгээр нь ангилан харвал жижиг бизнес эрхлэгчдийн дунд орлого буурсан ААН-үүд хамгийн өндөр (62%) хувьтай байна.

## БҮЛЭГ 2

*Бизнесийн  
орчин*

- **Зардал**

ААН-үүдийн 59%-д нь зардал өнгөрсөн жилтэй харьцуулахад өссөн байна. 2020 онд нийт ААН-үүдийн 38%-д зардал өссөн гэж байсан бол 2021 онд ААН-үүдийн дийлэнх (59%) нь зардал өссөн гэж хариулсан байна. Үүнээс барилга (71%), аж үйлдвэр (61%)-ийн салбаруудад болон том, дунд бизнес эрхлэгчдийн хувьд зардал хамгийн өндөр өсөлттэй байна. Зардлын байдлын чиглэлийн индекс -0.88 буюу өмнөх жилтэй (-0.90) ойролцоо түвшинд байна. Индексийг үзүүлэлтүүдээр нь задлан авч үзвэл төрийн үйлчилгээний хураамж, шимтгэлийн төлбөр, түүхий эд, материалын зардал, зээлийн хүү, санхүүгийн байгууллагын хураамж шимтгэл хамгийн хүндрэлтэй гэсэн бол ус, цахилгаан, дулааны зардал нь хамгийн бага хүндрэлтэй байна гэж хариуллаа.

## БҮЛЭГ 3

*Бизнесийн  
үйл  
ажиллагаа*

- **Хүчин чадлын ашиглалт**

Хүчин чадал ашиглалтын түвшин 2021 онд дунджаар 62%-тай байж 2020 оноос 9%-аар буурсан байна. Тус үзүүлэлт орон нутагт 67%, Улаанбаатарт 59%-тай байна. Тоног төхөөрөмжийн ашиглалтын түвшин сүүлийн 3 жилийн дунджаар 70% ашиглаж байсан бол Ковид гарснаас хойш (2020.02 сараас) 54%-ийг ашиглаж байна.

## БҮЛЭГ 4

*Санхүүжилт,  
дэмжлэг*

## БҮЛЭГ 5

*Цар тахал,  
ЗГ-ын төсөл  
хөтөлбөрийн  
нөлөө*




### 3. БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Энэ бүлэгт бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны орлого, зарлагын бүтэц, өөрчлөлт болон үйл ажиллагаанд учирч буй хүндрэлүүдийг авч үзнэ. Мөн бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалтын талаарх тооцооллын үр дүнг танилцуулна.

#### 3.1 Орлого

Судалгаанд оролцсон нийт ААН-ийн 58%-д (Улаанбаатар 57%, орон нутаг 59%) нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд борлуулалтын орлого буурсан байна. Энэ жилийн хувьд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор удаан хугацааны хөл хорио, хил гаалийн болон тээвэр логистикийн хүндрэл, ачаа тээврийн гацалтаас шалтгаалан эдийн эдийн засгийн өсөлт буурч, зарим бизнесийн үйл ажиллагаанууд зогсонги байдалд орсон нь ААН-үүдийн орлого нэлээд буурахад нөлөөлсөн байна. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн 22%-д нь орлого өссөн бол Улаанбаатарт үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчдийн 21%-д нь орлого өссөн байна. Харин Улаанбаатар хотын ААН-үүдийн 22%, орон нутгийн ААН-үүдийн 19%-д орлогод өөрчлөлт ороогүй байна /Дүрслэл 3.1/.


**Дүрслэл 3.1 | Өмнөх онтой харьцуулахад орлого өөрчлөгдсөн эсэх**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Цар тахлаас шалтгаалан ААН-үүдийн орлого сүүлийн 2 жил дараалан буюу харгалзан 54% болон 58%-иар буурсан гэж хариуллаа /Дүрслэл 3.2/.


**Дүрслэл 3.2 | 2020, 2021 оны орлогын өөрчлөлтийн харьцуулалт**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Орлогын өөрчлөлтийг аймгуудаар авч үзвэл Завхан, Хөвсгөл, Говьсүмбэр, Увс аймгуудад орлого хамгийн ихээр (нийт ААН-ийн 74-88%-д) буурч, Архангай, Ховд, Баян-Өлгий аймгуудад хамгийн багаар (нийт ААН-ийн 39%-48%-д) буурсан байна. Харин Дорноговь аймагт үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн 33%-д нь орлого өссөн нь аймгуудаас хамгийн өндөр үзүүлэлт байна /Дүрслэл 3.3/.

**Дүрслэл 3.3 | Орлогын өөрчлөлт, аймгуудаар**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Орлогын өөрчлөлтийг ААН-үүдийн үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл ХАА, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн орлого хамгийн ихээр буурчээ. Харин аж үйлдвэр, барилгын салбарт орлогын бууралт бусад салбаруудаас харьцангуй бага байна /Дүрслэл 3.4/.


**Дүрслэл 3.4 | Орлогын өөрчлөлт, салбараар**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Мөн ААН-үүдийг хэмжээгээр нь ангилан харвал жижиг бизнес эрхлэгчдийн дунд орлого буурсан ААН-үүд хамгийн өндөр (62%) хувьтай байна. Харин том ААН-үүдийн 34%-д нь орлого өссөн нь хамгийн өндөр үзүүлэлт байна /Дүрслэл 3.5/.

**Дүрслэл 3.5 | Орлогын өөрчлөлт, ААН-ийн хэмжээгээр**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

ААН-үүдийн бизнесийн орлогын 86%-ийг бараа, ажил, үйлчилгээнээс олсон үндсэн үйл ажиллагааны орлого, 5%-ийг түрээсийн орлого бүрдүүлж байна. Харин

9%-ийг хүүний орлого, үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого зэрэг бусад орлого бүрдүүлж байна /Дүрслэл 3.6/.


**Дүрслэл 3.6 | ААН-ийн бизнесийн орлогын бүтэц**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Мөн ААН-үүдийн хувьд орлогоо хэрхэн нэмэгдүүлэх талаарх боломжийг судалсан бөгөөд дийлэнх нь бараа, ажил, үйлчилгээ зэрэг үндсэн үйл ажиллагааг сайжруулж бизнесээ тэлэх, ажлын бүтээмжийг дээшлүүлж, шинээр бараа, үйлчилгээ нэвтрүүлснээр орлогоо нэмэгдүүлэх боломжтой байна гэсэн байна /Дүрслэл 3.7/.

**Дүрслэл 3.7 | Орлого нэмэгдүүлэх боломж**




Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

### 3.2 Зардал

Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн 59%-д нь зардал өнгөрсөн жилтэй харьцуулахад өссөн, 21%-д нь буурсан бол 20%-д нь өөрчлөгдөөгүй байна. Цар тахалтай холбоотойгоор удаан хугацааны хөл хорио, хил гаалийн болон тээвэр логистикийн хүндрэл, ачаа тээврийн гацалтаас шалтгаалан тээврийн зардал нэмэгдсэнээс гадна шатахууны үнэ өссөн, төгрөгтэй харьцах юанийн ханш чангарсан зэрэг нь ААН-үүдийн нийт зардал өсөхөд нөлөөлжээ. Үүнээс орон нутагт бизнес эрхлэгчдийн зардлын өсөлт харьцангуй өндөр байна. Тухайлбал, орон нутгаас оролцсон ААН-үүдийн 68% нь, харин Улаанбаатар хотод бизнес эрхлэгчдийн 56% нь зардал өссөн гэж хариулжээ. Харин Улаанбаатар хотын ААН-үүдийн 22%-д зардал өнгөрсөн жилээс өөрчлөгдөөгүй, 22%-д нь буурсан байна. Орон нутгийн хувьд буурсан гэсэн хариулт 19%, өөрчлөгдөөгүй гэсэн хариулт 13% байна /Дүрслэл 3.8/.

**Дүрслэл 3.8 | Өмнөх онтой харьцуулахад зардал өөрчлөгдсөн эсэх**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

2020 онд нийт ААН-үүдийн 38%-д зардал өссөн гэж байсан бол 2021 онд ААН-үүдийн дийлэнх (59%) нь зардал өссөн гэж хариулсан байна /Дүрслэл 3.9/.


**Дүрслэл 3.9 | 2020, 2021 оны зардлын өөрчлөлтийн харьцуулалт**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Зардлын өөрчлөлтийг аймгуудаар авч үзвэл Увс, Хэнтий, Архангай, Хөвсгөл, Говь-Алтай аймгуудад зардал хамгийн ихээр (нийт ААН-ийн 81-89%-д) нэмэгдэж, Төв, Дорнод, Говьсүмбэр, Дархан-Уул аймгуудад хамгийн багаар (нийт ААН-ийн 48-56%-д) нэмэгдсэн байна. Харин Говьсүмбэр аймагт үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн 44%-д нь зардал буурсан нь аймгуудаас хамгийн өндөр үзүүлэлт байна /Дүрслэл 3.10/.

**Дүрслэл 3.10 | Зардлын өөрчлөлт, аймгуудаар**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Эдийн засгийн салбараар харвал барилга (71%), аж үйлдвэр (61%)-ийн салбаруудад зардал өссөн ААН-үүд бусад салбаруудаас харьцангуй өндөр байна. Харин ХАА-н салбар (25%), худалдааны салбар (23%)-т зардал буурсан хувь харьцангуй өндөр байна /Дүрслэл 3.11/.


**Дүрслэл 3.11 | Зардлын өөрчлөлт, салбараар**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Зардлын өөрчлөлтийг ААН-үүдийн хэмжээгээр авч үзвэл том, дунд бизнес эрхлэгчдийн хувьд зардал өссөн гэсэн хариулт бусад ААН-ээс харьцангуй өндөр, зардал буурсан гэсэн хариулт харьцангуй бага байна /Дүрслэл 3.12/.

**Дүрслэл 3.12 | Зардлын өөрчлөлт, ААН-ийн хэмжээгээр**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

ААН-үүдийн хувьд зардлаа бууруулах боломжийг судалсан бөгөөд дийлэнх нь түүхий эд, материалын өртөг, үйл ажиллагааны бусад зардлуудаа бууруулснаар зардлаа бууруулах боломжтой гэсэн байна /Дүрслэл 3.13/.

**Дүрслэл 3.13 | Зардал бууруулах боломж**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

### Шигтгээ 7: ААН-ийн бодит орлого, зардлын өсөлт

Судалгааны үр дүнг бодит тоон үзүүлэлттэй харьцуулах зорилгоор ААН-ийн бодит орлого, зардлын өсөлтийг Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн И-баланс системийн өгөгдлийг ашиглан тооцов.


Монгол Улсын хэмжээнд 2021 оны хагас жилийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа бүх хувийн хэвшлийн ААН-ийн орлогын тайланг ашигласнаас 2020 болон 2021 оны хагас жилийн аль нэг тайлангаа оруулаагүй, тайлангийн орлого, зардлын өгөгдөл дутуу ААН-ийг түүврээс хасч 9,432 ААН-ийн орлогын тайланг үндэслэн тооцоолов.

2021 оны хагас жилийн байдлаар нийт ААН-ийн 59.4%-д борлуулалтын болон бусад орлогын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс өссөн бол 0.3%-д өөрчлөгдөөгүй, 40.3%-д буурсан үзүүлэлттэй байна.

Түүнчлэн борлуулсан бүтээгдэхүүний өртөг болон бусад зардлын нийт хэмжээ 2021 оны хагас жилийн байдлаар 2020 оны хагас жилээс нийт ААН-ийн 58.8%-д өссөн байна. Мөн нийт ААН-ийн 0.2%-д зардал огт өөрчлөгдөөгүй бол 40.9%-д зардал буурсан байна.

Тус тооцооллын үр дүнг судалгааны үр дүнтэй харьцуулбал зардал өссөн ААН-

ийн хэмжээ түүвэр судалгааны үр дүнтэй ойролцоо түвшинд (нийт ААН-ийн 59%) байгаа бол орлого нь буурсан ААН-ийн хэмжээ түүвэр судалгааны хариултаас 18 нэгж хувиар бага байна.




Эх сурвалж: И-баланс цахим санхүүгийн тайлангийн систем, Сангийн яам (2021)

### Зардлын байдлын чиглэлийн индекс:

Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд үзүүлж буй зардлын байдлыг тооцох зорилгоор чиглэлийн индексийг тооцоход ерөнхий индекс -0.88 буюу Монголбанкнаас 2011-2018 онуудад хийгдсэн ЖДҮ-ийн хөгжил, санхүүжилтийн байдал түүвэр судалгааны ерөнхий индексийн дундаж (-0.89) болон өмнөх жилтэй (-0.90) ойролцоо түвшинд байна /Дүрслэл 3.14/.

### Дүрслэл 3.14 | Зардлын байдал, чиглэлийн индекс

-2=маши их хүндрэлтэй, -1.5= их хүндрэлтэй, -1=дунд хүндрэлтэй, -0.5=бага хүндрэлтэй, 0=хүндрэлгүй




Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

2020 онтой адил барилга, аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаагаа явуулахад гарч буй зардлын хүндрэлийн түвшин бусад салбараас харьцангуй өндөр байна. /Дүрслэл 3.15/.

### Дүрслэл 3.15 | Зардлын байдал, салбараар

-2=маши их хүндрэлтэй, -1.5= их хүндрэлтэй, -1=дунд хүндрэлтэй, -0.5=бага хүндрэлтэй, 0=хүндрэлгүй




Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Зардлын байдлыг ААН-үүдийн хэмжээгээр ангилан авч үзвэл жижиг, дунд ААН-үүд үйл ажиллагааны зардлын хүндрэл том болон бичил ААН-тэй харьцуулахад илүү өндөр байна. /Дүрслэл 3.16/.

### Дүрслэл 3.16 | Зардлын байдал, ААН-ийн хэмжээгээр

-2=маши их хүндрэлтэй, -1.5= их хүндрэлтэй, -1=дунд хүндрэлтэй, -0.5=бага хүндрэлтэй, 0=хүндрэлгүй



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Зардлын бүлгийн индексийг үзүүлэлтүүдээр нь задлан авч үзвэл төрийн үйлчилгээний хураамж, шимтгэлийн төлбөр хамгийн их хүндрэл учруулж байна. Ийнхүү хариулахад 2020 онд хэрэгжүүлсэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт 2021 онд

цуцлагдаж ААН-үүд татвараа эргэн төлж эхэлсэн нь нөлөөлсөн байж болзошгүй байна /Шигтгээ 8/. Түүнчлэн түүхий эд, материалын зардал, зээлийн хүү, санхүүгийн байгууллагын хураамж шимтгэл, зам, тээврийн зардал нь ААН-үүдийн үйл ажиллагаанд дарамт үзүүлж байна. Харин Засгийн газрын зүгээс ус, цахилгаан, дулааны төлбөрийг тэглэсэнтэй холбоотойгоор дээрх зардлууд нь бусад зардлуудаас харьцангуй бага хүндрэл учруулж байна гэж хариуллаа. Эдгээр үзүүлэлтүүд нь 2020 оны түвшинтэй харьцуулахад ойролцоо түвшинд байна. /Дүрслэл 3.17/.

#### Дүрслэл 3.17 | Зардлын байдал, үзүүлэлтээр

-2= маш их хүндрэлтэй, -1.5= их хүндрэлтэй, -1= дунд хүндрэлтэй, -0.5= бага хүндрэлтэй, 0= хүндрэлгүй



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

#### Шигтгээ 8: Улсын төсвийн орлого

Улсын төсвийн орлого 2020 оны III улиралтай харьцуулахад 2021 оны III улирлын байдлаар 52%-ийн өсөлттэй байна. Үүнээс ААНОАТ 114%, ХХОАТ 33%, Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 25%, бусад татварын орлого 39%-аар өссөн байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа ААН-ийн тоо 2020 оны III улиралтай харьцуулахад 2021 оны III улирлын байдлаар 2.1%-аар буурсан байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа ААН-ийн тоо 2.1%-аар буурсан байхад улсын татварын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэмэгдэж, сайжирснаас үзвэл цар тахлын олон удаагийн хөл хорио бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байсан ч улсын татварын орлого, төрийн үйлчилгээний шимтгэл хураамж бүрдүүлэлт хэвийн ажиллаж, энэ нь эргээд бизнес эрхлэгчдэд хамгийн хүндрэлтэй зардлын төрлөөр нэрлэгдсэн байх боломжтой юм.

Төсвийн орлого	Өсөлт
Улсын төсвийн орлого	52.2%
Татварын орлого	39.6%
Орлогын албан татвар	83.3%
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	113.6%
Хувь хүний орлогын албан татвар	32.6%
Нийгмийн даатгалын орлого	24.8%
Хөрөнгийн/өмчийн албан татвар	19.4%
Нэмэгдсэн өртгийн албан татвар	28.6%
Онцгой албан татвар	9.8%
Бусад татвар	39.3%
Татварын бус орлого	90.2%

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, ҮСХ (2021)

Зардлын байдлыг салбарын ангиллаар авч үзвэл бүх салбарт жигд тархалттай бөгөөд ХАА, аж үйлдвэр, худалдаа, үйлчилгээний салбарт төрийн байгууллагын шимтгэл хураамж болон зээлийн хүүний зардал, түүхий эд материалын зардал хүндрэлтэй байдаг. Харин барилгын салбарт түүхий эд, материалын зардал бусад зардлаас илүү ихээр хүндрэл учруулж байна /Хүснэгт 3/.



**Хүснэгт 3 | Зардлын байдал, салбараар**

-2= маш их хүндрэлтэй, -1.5= их хүндрэлтэй, -1= дунд хүндрэлтэй, -0.5= бага хүндрэлтэй, 0= хүндрэлгүй

Зардлын төрөл	ЭЗҮА-ны салбараар				
	ХАА	Аж үйлдвэр	Барилга	Дотоод худалдаа	Үйлчилгээ
Түрээсийн зардал	-0.95	-0.87	-0.90	-0.83	-0.97
Түүхий эд, материалын зарда	-1.11	-1.33	-1.42	-1.10	-1.13
Тоног төхөөрөмжийн зардал	-1.05	-0.99	-1.08	-0.87	-1.01
Хүний нөөцийн зардал	-1.01	-0.92	-1.00	-0.86	-0.96
Дулааны зардал	-0.54	-0.61	-0.55	-0.58	-0.59
Усны зардал	-0.48	-0.50	-0.50	-0.47	-0.49
Цахилгааны зардал	-0.58	-0.63	-0.52	-0.57	-0.58
Зам, тээврийн зардал	-0.96	-1.01	-1.04	-1.01	-0.90
Үйл ажиллагааны бусад зард	-0.78	-0.77	-0.78	-0.76	-0.79
Харилцаа холбоо, борлуулалт,	-0.65	-0.60	-0.56	-0.62	-0.65
Зээлийн хүүний зардал	-1.15	-1.18	-1.19	-1.17	-1.14
Хураамж, шимтгэл	-0.99	-1.02	-1.03	-1.11	-1.02
Төрийн шимтгэл хураамжийн	-1.19	-1.19	-1.26	-1.24	-1.22
<b>Нийт</b>	<b>-0.88</b>	<b>-0.89</b>	<b>-0.91</b>	<b>-0.86</b>	<b>-0.88</b>

Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

ААН-ийн хэмжээгээр ангилан зардлын хүндрэлийг харвал бичил, том бизнес эрхлэгчдэд санхүүгийн болон төрийн байгууллагын шимтгэл хураамж, түүхий эд материалын зардал, зээлийн хүүний зардал, жижиг, дунд ААН-үүдэд эдгээрээс гадна тоног төхөөрөмжийн зардал, хүний нөөцийн зардал илүүтэйгээр хүндрэлтэй байдаг байна /Хүснэгт 4/.

**Хүснэгт 4 | Зардлын байдал, ААН-ийн хэмжээгээр**

-2= маш их хүндрэлтэй, -1.5= их хүндрэлтэй, -1= дунд хүндрэлтэй, -0.5= бага хүндрэлтэй, 0= хүндрэлгүй

Зардлын төрөл	Хэмжээгээр			
	Бичил	Жижиг	Дунд	Том
Түрээсийн зардал	-0.91	-0.79	-0.73	-0.76
Түүхий эд, материалын зарда	-1.15	-1.28	-1.36	-1.17
Тоног төхөөрөмжийн зардал	-0.94	-1.05	-1.17	-0.96
Хүний нөөцийн зардал	-0.91	-1.02	-1.16	-0.90
Дулааны зардал	-0.57	-0.65	-0.67	-0.54
Усны зардал	-0.47	-0.58	-0.59	-0.54
Цахилгааны зардал	-0.56	-0.67	-0.70	-0.59
Зам, тээврийн зардал	-0.98	-0.99	-1.03	-1.04
Үйл ажиллагааны бусад зард	-0.76	-0.86	-0.73	-0.77
Харилцаа холбоо, борлуулалт, маркетингийн зардал	-0.63	-0.59	-0.59	-0.57
Зээлийн хүүний зардал	-1.17	-1.21	-1.16	-1.08
Хураамж, шимтгэл	-1.07	-1.06	-0.88	-1.05
Төрийн шимтгэл хураамжийн	-1.22	-1.21	-1.22	-1.32
<b>Нийт</b>	<b>-0.87</b>	<b>-0.92</b>	<b>-0.92</b>	<b>-0.87</b>


Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Зардлын байдлыг аймаг, дүүргээр харьцуулахад Орхон, Дархан-Уул, Завхан, Хөвсгөл аймгуудын бизнес эрхлэгчид зардлын байдал хамгийн ихээр хүндрэлтэй байдаг буюу муу үнэлгээ өгсөн бол Говьсүмбэр аймаг, Налайх, Багахангай,

Чингэлтэй дүүрэг, Дундговь аймгийн бизнес эрхлэгчид харьцангуй бага хүндрэлтэй байна гэсэн үнэлгээ өгчээ /Дүрслэл 3.18/.

**Дүрслэл 3.18 | Зардлын байдал, аймаг болон дүүргээр**

-2= маш их хүндрэлтэй, -1.5= их хүндрэлтэй, -1= дунд хүндрэлтэй, -0.5= бага хүндрэлтэй, 0= хүндрэлгүй




Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

**3.3 Хүчин чадлын ашиглалт**

Судалгааны үр дүнгээс харахад хүчин чадал ашиглалт (ХЧА)-ын түвшин 2021 онд дунджаар 62%-тай байж 2020 оноос 9%-аар буурсан байна. Ковид-19 цар тахалтай холбоотойгоор урт хугацааны хөл хорио, хил гаалийн болон тээвэр логистикийн хүндрэл, ачаа тээврийн гацалтаас шалтгаалан бизнесийн үйл ажиллагаанууд зогсонги байдалд орсон нь ХЧА-ын түвшин буурахад нөлөөлсөн гэж дүгнэж болохоор байна. Хүчин чадлын ашиглалт орон нутагт 67%, Улаанбаатар хотод 59%-тай байна. /Дүрслэл 3.19/.


Дүрслэл 3.19 | Хүчин чадлын ашиглалт



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Байршлын хувьд орон нутгийн дундаж хүчин чадлын ашиглалт нийслэлтэй харьцуулахад өндөр байна. ААН-ийн хэмжээгээр задалж үзвэл Улаанбаатар хот, орон нутагт том, дунд ААН-үүд хүчин чадлынхаа илүү өндөр хувийг ашиглаж байна /Дүрслэл 3.20/.


Дүрслэл 3.20 | Хүчин чадлын ашиглалт, ААН-ийн хэмжээ, байршлаар



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Хүчин чадлын ашиглалтыг салбарын ангиллаар авч үзвэл худалдааны салбар (63%) хамгийн өндөр ашиглалттай байгаа бол ХАА, аж үйлдвэрийн салбар тус тус 59%-аар хүчин чадлаа хамгийн багаар ашиглаж байна /Дүрслэл 3.21/.

Дүрслэл 3.21 | Хүчин чадлын ашиглалт, салбараар



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Тоног төхөөрөмжийн ашиглалтын түвшин сүүлийн 3 жилийн дунджаар 70% ашиглаж байсан бол ковид гарснаас хойш (2020.02 сараас) 16 нэгж хувиар буурч 54%-д хүрчээ /Хүснэгт 5/.

Хүснэгт 5 | Тоног төхөөрөмж ашиглалт

	Тоног төхөөрөмж ашиглалт	
	Сүүлийн 3 жилийн дундаж	Ковид гарснаас хойш
Улаанбаатар	69%	54%
Орон нутаг	72%	53%
Аж үйлдвэр	67%	51%
Барилга	72%	51%
Дотоод худалдаа	69%	56%
Үйлчилгээ	72%	53%
ХАА	72%	55%
Бичил	69%	53%
Дунд	74%	54%
Жижиг	72%	52%
Том	77%	62%
	<b>70%</b>	<b>54%</b>

Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Ажиллагсдын тоо Улаанбаатар хотод хамгийн өндөр орлоготой жилтэй харьцуулахад 29%-аар, өнгөрсөн онтой харьцуулахад 5.4%-аар буурсан байна. Харин орон нутагт харьцангуй бага хувиар буурсан байна /Дүрслэл 3.22/.

**Дүрслэл 3.22 | Ажилчдын тоо, байршлаар**

Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Барилгын салбарт ажиллагчдын тоо өнгөрсөн онтой харьцуулахад 13%-аар буурсан бол үйлчилгээний салбарын ажилчдын тоо бага зэрэг /1%/ өссөн байна /Дүрслэл 3.23/.

**Дүрслэл 3.23 | Ажилчдын тоо, салбараар**

Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

**Шигтгээ 9.: Ажиллагчдын тоо**

Үндэсний статистикийн хорооны мэдээллээр ажиллагсдын тоо 2020 оны III улиралтай харьцуулахад 2021 оны III улирлын байдлаар 3.4%-аар буурсан байна. Энэ нь түүвэр судалгааны үр дүнтэй ойролцоо түвшинд байна.

Салбарын ангиллаар авч үзвэл барилгын салбарт ажиллагчдын тоо 7.8%-аар нэмэгдэж, бусад салбарт буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс худалдааны салбарт ажиллагчдын тоо 11.8%-аар буурсан байна.

Салбарын ангилал	Өсөлт
Аж үйлдвэр	-1.8%
Барилга	7.8%
Дотоод худалдаа	-11.8%
Үйлчилгээ	-3.8%
ХАА	-2.3%
<b>Нийт</b>	<b>-3.4%</b>


Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, YCX (2021)

Том ААН-ийн ажиллагсдын тоо өнгөрсөн онтой харьцуулахад хамгийн бага буюу 2%-аар буурсан бол бусад ААН дунджаар 7-8% буурсан байна. /Дүрслэл 3.24/.

**Дүрслэл 3.24 | Ажилчдын тоо, ААН-ийн хэмжээгээр**

Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Нэг ажилтны өдөрт ажиллах цагийн дундаж Улаанбаатар хотод хамгийн өндөр орлоготой жилтэй харьцуулахад 5%-аар буурсан бол, өнгөрсөн онтой харьцуулахад 7%-аар нэмэгдсэн байна. Харин орон нутагт харьцангуй 3-4%-аар хувиар буурсан байна /Дүрслэл 3.25/.

**Дүрслэл 3.25 | Нэг ажилтны өдөрт ажиллах цагийн дундаж, байршлаар**

Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

ААН-ийн сарын дундаж орлого Улаанбаатар хотод хамгийн өндөр орлоготой жилтэй харьцуулахад 39%-аар буурсан бол, өнгөрсөн онтой харьцуулахад 4%-аар буурсан байна. Орон нутагт хамгийн өндөр орлоготой жилтэй харьцуулахад 22%-аар, 2020 онтой харьцуулахад 7%-аар буурсан байна /Дүрслэл 3.26/.

**Дүрслэл 3.26 | ААН-ийн сарын дундаж орлого, байрилаар**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Үүнийг нэгтгэн дүгнэвэл, Ковид-19 цар тахалтай холбоотойгоор урт хугацааны хөл хорио, хил гаалийн болон тээвэр логиستيкийн хүндрэл, ачаа тээврийн гацалтаас шалтгаалан бизнесийн үйл ажиллагаанууд зогсонги байдалд орсноос шалтгаалан хүчин чадлын ашиглалтын ерөнхий түвшин 2020 оноос 9%-аар, хэвийн үе (цар тахлаас өмнөх үе)-ээс 20 орчим хувиар буураад байна.

# БИЗНЕСИЙН САНХҮҮЖИЛТ, ДЭМЖЛЭГ

Энэ жилийн судалгааны үр дүнгээс ААН-үүдэд үзүүлж буй дэмжлэг, санхүүжилтийн орчны нөхцөл байдлыг хураангуйлбал дараах байдалтай байна.

## БҮЛЭГ 1

*Ерөнхий  
мэдээлэл*

## БҮЛЭГ 2

*Бизнесийн  
орчин*

## БҮЛЭГ 3

*Бизнесийн  
үйл  
ажиллагаа*

## БҮЛЭГ 4

*Санхүүжилт,  
дэмжлэг*

## БҮЛЭГ 5

*Цар тахал,  
ЗГ-ын төсөл  
хөтөлбөрийн  
нөлөө*

- **Дэмжлэг:** ААН-үүдэд хамгийн ихээр банкууд болон төрийн байгууллагууд (УИХ, ЗГ, ОНЗЗ)-ын зүгээс санхүүжилт олгох, татварын дэмжлэг, сургалт, зөвлөгөөн явуулах байдлаар дэмжлэг үзүүлдэг байна.
- **Дэмжлэг үзүүлэх арга хэмжээний санал:** ААН-үүдийн зүгээс банк болон төр, засгаас бага өртөгтэй санхүүжилт, татварын таатай орчин, чирэгдэлгүй төрийн үйлчилгээ зэргийг хүлээж байна.
- **Санхүүжилтийн эх үүсвэр:** Судалгаанд хамрагдсан ААН-үүд ихэвчлэн дотоодын банк, санхүүгийн байгууллага болон өөрсдийн дотоод нөөц бололцоонд тулгуурлан санхүүжилтийн хэрэгцээгээ шийдвэрлэж байна. ААН-үүдийн дотоодын санхүүжилтийн дийлэнх хувийн эх үүсвэрийг арилжааны банк бүрдүүлж байна.
- **Санхүүжилтийн зарцуулалт:** Гадаад, дотоод санхүүгийн байгууллагаас авсан санхүүжилтээ өмнөх жилүүдэд ихэвчлэн хөрөнгө оруулалтын шинж чанартай зардлыг санхүүжүүлэхэд зарцуулдаг байсан бол энэ жилийн хувьд эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлэхэд зарцуулжээ.
- **Зээл авах болон төлөхөд учирч буй хүндрэл:** Барьцаа хөрөнгийн үнэлгээ доогуур, зээлийн нөхцөл хатуу байгаа нь зээл авахад голлон хүндрэл үзүүлж байна гэж хариулсан бол бизнесийн орчин муудсан, төгрөгийн ханш (юань-төгрөг) болон инфляцын дарамт өндөр байгаа нь эргэн төлөлтөд сөргөөр нөлөөлж байна гэж хариуллаа.
- **Дэмжлэг үзүүлэх санхүүжилтийн хэмжээ, хугацаа:** ААН-үүдийн талаас илүү хувь буюу 55% нь 50-500 сая төгрөгийн санхүүжилт үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлнэ гэж хариулсан байна. Түүнчлэн ААН-үүдийн дийлэнх нь 3-10 жилийн хугацаатай зээл авах сонирхолтой байна.


## 4. БИЗНЕСИЙН САНХҮҮЖИЛТ, ДЭМЖЛЭГ

### 4.1 Дэмжлэг

Энэ бүлэгт бизнес эрхлэгчдэд үзүүлдэг дэмжлэг болон цаашид авах шаардлагатай арга хэмжээнүүдийн талаарх санал асуулгын үр дүнг танилцуулна.

Судалгаанд оролцогчдын 25% нь (давхардсан тоогоор) арилжааны банкууд, 10% нь УИХ болон Засгийн газар нь бизнес эрхлэгчдийг хамгийн ихээр дэмждэг гэж хариуллаа. Мөн орон нутгийн засаг захиргаа (8%), олон улсын байгууллагууд, бусад санхүүгийн байгууллагууд, худалдаа аж үйлдвэрийн танхимын дэмжлэг ойролцоо буюу 4% орчим хувийг эзэлж байна. Харин “Мэдэхгүй” гэсэн хариултын хувийн жин өнгөрсөн жилтэй харьцуулахад нэмэгдсэн байна.

#### Дүрслэл 4.1 | ААН-үүдийг хамгийн ихээр дэмждэг байгууллага



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Энэ жилийн судалгааны үр дүнг өнгөрсөн жилийнхтэй харьцуулбал өнгөрсөн жилийн хамгийн өндөр дэмжлэг үзүүлдэг байгууллагууд болох арилжааны банк болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын хувийн жин буурсан байна.

Дээрх байгууллагуудаас бизнес эрхлэгчдэд голлон санхүүжилт олгох (27%), сургалт, зөвлөгөө явуулах (7%), татварын бодлогоор дэмжих (5%) болон бизнес эрхлэгчдийн эрх зүйн орчныг сайжруулах (5%) зэргээр дэмжлэг үзүүлдэг байна. Энэ жилийн судалгааны үр дүнгээс харахад “мэдэхгүй” (27%), “дэмжлэг үзүүлдэггүй” (11%) гэсэн хариултууд өндөр хувьтай байна. Ялангуяа худалдааны салбарынхны 14%, барилгын салбарынхны 10% нь “дэмжлэг үзүүлдэггүй” гэж хариулсан байна. Түүнчлэн үйлчилгээ, худалдаа болон барилгын салбарынхны 27-29% нь “мэдэхгүй” гэсэн хариултыг сонгожээ.

#### Дүрслэл 4.2 | Бизнесийн байгууллагад ирж буй дэмжлэг



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

ААН-үүдийн гол дэмжлэг болох санхүүжилт нь барилгын салбарт хамгийн өндөр буюу 34%, худалдааны салбарт 29%-тай байна.

“Мэдэхгүй” болон “дэмжлэг үзүүлдэггүй” гэсэн хариултуудын эзлэх хувь бичил ААН-үүдийн хувьд өндөр байгаа бол бусад ААН-үүдийн хувьд харьцангуй жигд байна. Санхүүжилтийн дэмжлэг дунд ААН-үүдэд хамгийн өндөр (39%) байгаа бол бичил ААН-үүдэд хамгийн бага (25%) байна.

Судалгаанд оролцсон ААН-үүд нэн тэргүүнд татварын таатай орчинг бүрдүүлэх (17%), төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох (17%) нь бизнесийн үйл ажиллагаанд хамгийн чухал дэмжлэг болно гэж үзэж байна. Мөн авилга (10%),



зөвшөөрөл, лицензийн тоог бууруулах (9%), хууль эрхзүйн орчинг сайжруулах (7%) сайжруулах шаардлагатай байна гэж үзэж байна.


**Дүрслэл 4.3 | Бизнесийг хөгжүүлэхэд нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Өнгөрсөн жилтэй харьцуулахад авилгыг бууруулах, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, зөвшөөрөл, лицензийн тоог бууруулах зэрэг хууль эрх зүйн орчинг сайжруулах чиглэлийн дэмжлэгүүд 1-2 байраар ухарсан бол татварын таатай орчинг бүрдүүлэх, хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэрийн хүртээмжийг нэмэгдүүлэх гэсэн дэмжлэгүүд 2 болон 4 байраар тус тус урагшилсан байна.

**Дүрслэл 4.4 | Бизнесийн байгууллагад ирж буй дэмжлэг, эрэмбийн өөрчлөлт**




Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

## 4.2 Санхүүжилт

Судалгаанд хамрагдсан ААН-үүд ихэвчлэн дотоодын банк, санхүүгийн байгууллага болон өөрсдийн дотоод нөөц бололцоо (харгалзан 35% болон 63%-нд тулгуурлан санхүүжилтийн хэрэгцээгээ шийдвэрлэж байна.


**Дүрслэл 4.5 | Санхүүжилтийн эх үүсвэр, ААН-ийн хэмжээгээр**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Бичил ААН-үүд ихэвчлэн (69%) өөрсдийн дотоод нөөц бололцоо буюу үйл ажиллагааны орлого дээр тулгуурлан санхүүжилтийн хэрэгцээгээ хангадаг бол бусад ААН-үүд өөрсдийн эх үүсвэрээс гадна (44-51%) гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагуудаас (49-56%) санхүүжилт авдаг байна. Гадаад эх үүсвэрийн санхүүжилт том ААН-үүдэд хамгийн өндөр (10%) байна. Салбараар нь авч үзвэл бичил болон жижиг ААН-үүд голчлон үйл ажиллагаа явуулдаг салбарууд болох ХАА, үйлчилгээ болон худалдааны салбарт өөрсдийн эх үүсвэрийн санхүүжилт зонхилж байгаа бол аж үйлдвэр, барилгын салбарт харьцангуй бага байна.

**Дүрслэл 4.6 | Санхүүжилтэд хамрагдсан байдал, салбараар**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

ААН-үүдийн дотоодын санхүүжилтийн дийлэнх буюу 59 хувийн эх үүсвэрийг арилжааны банк бүрдүүлж байна. Түүнчлэн ББСБ-ууд ААН-үүдийн санхүүжилтийн эх үүсвэрийн 13%-ийг бүрдүүлж байна гэсэн дүн гарчээ.

**Дүрслэл 4.7 | Санхүүжилтийн эх үүсвэр**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Санхүүжилтэд хамрагдаж байсан ААН-үүдийн хувьд санхүүжилт авахад барьцаа хөрөнгийн үнэлгээ доогуур (24 хувь) болон зээлийн нөхцөл, зээл олгох үйл ажиллагаа (21 хувь) нь голчлон хүндрэл үзүүлж байна гэж хариулсан байна. Түүнчлэн бичиг, баримтын бүрдүүлэлт болон өндөр шимтгэл хураамж, батлан даалтад хамрагдах боломж зэрэг нь ААН-үүдэд багагүй хүндрэл учруулж байна. Цар тахлын үед банкууд зээлийн шалгуур, нөхцөлөө сулруулсан /Шигтгээ 10/ хэдий ч судалгаанд хамрагдсан ААН-үүдийн зүгээс

дарамт үзүүлсэн хэвээр байна гэж үзэж байна.

**Дүрслэл 4.8 | Санхүүжилт авахад тулгарч буй хүндрэлүүд**




Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

#### **Шигтгээ 10: Банкуудын ААН-үүдэд олгох зээлийн шалгуур, нөхцөлд гарсан өөрчлөлт**

Монголбанкны зүгээс банкуудаас олгож буй зээлийн шалгуур, нөхцөл, эрэлт болон нийлүүлэлт, тэдгээрийн цаашдын төлөвийг тодорхойлох зорилгоор улирал тутам “Банкны зээлийн төлөв” сэдэвт судалгааг хийж гүйцэтгэж байна. Тус судалгааны 2021 оны 3 дугаар улирлын тайлангаас харахад банкууд цар тахлын эхэн үед зээлийн шалгуураа огцом чангаруулсан бол 2020 оны 2 улирлаас эхлэн 2021 оны 2 дугаар улирал хүртэл ААН-д олгох зээлийн шалгуураа аажим сулруулж байсан байна. Ийнхүү сулруулахад эх үүсвэрийн өртөг, барьцаа хөрөнгийн эрсдэл буурсан нь голлон нөлөөлжээ.


*ААН-үүдэд олгох зээлийн шалгуурын индекс*



Эх сурвалж: Зээлийн төлөвийн судалгаа, Монголбанк (2021)

Зээлийн нөхцөлийн тухайд бодлогын хүү буурсан, мөн Монголбанкны зүгээс зээлийн хүүг бууруулах зарим арга хэмжээг авч хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор зээлийн хүү буурсан нь зээлийн нөхцөлийг сулруулахад голлон нөлөөлсөн байна.

#### ААН-ийн зээлийн нөхцөлийн индекс




Эх сурвалж: Зээлийн төлөвийн судалгаа, Монголбанк (2021)

Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн 40 хувь нь эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлэх зорилгоор зээл, санхүүжилт авдаг бол бизнесээ өргөжүүлэх (15%), машин тоног төхөөрөмж худалдан авах (14%), зээлээ дахин санхүүжүүлэх (10%) зориулалттай зээлүүд бусад зориулалтуудаас илүү түгээмэл байна. Энэ жилийн үр дүнг

өнгөрсөн жилийн судалгааны үр дүнтэй харьцуулахад цар тахалтай холбоотойгоор богино хугацааны санхүүжилт буюу эргэлтийн хөрөнгийн зориулалттай санхүүжилтийн эзлэх хувь нэмэгдсэн бол эсрэгээрээ хөрөнгө оруулалтын шинж чанартай санхүүжилтийнх буурсан байна.


#### Дүрслэл 4.9 | Санхүүжилтийн зарцуулалт



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Санхүүжилтийн зарцуулалтын зорилгыг салбараар ангилан авч үзвэл хөрөнгө оруулалтын (барилга худалдаж авах, барилгаа өргөжүүлэх, машин тоног төхөөрөмж худалдан авах, бизнесээ өргөжүүлэх, өөр бизнес эрхлэх) зорилгоор зээл авах хандлага хамгийн өндөр салбар нь аж үйлдвэрлэлийн салбар (47%) байгаа бол үүний дараа барилгын салбар (39%) орж байна. Худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн хувьд голчлон эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлэх (57%) зорилгоор зээл авдаг байна. ХАА болон үйлчилгээний салбаруудын хувьд бусад салбаруудтай харьцуулахад хөрөнгө оруулалт болон эргэлтийн хөрөнгөөс бусад зорилгоор зээл авах хандлагатай байна. Өмнөх жилтэй харьцуулахад бүх салбаруудын хувьд хөрөнгө оруулалтын санхүүжилтийн эзлэх хувь буурсан бол эргэлтийн хөрөнгийн шинж чанартай зээлийн эзлэх хувь нэмэгдсэн байна.


#### Дүрслэл 4.10 | Санхүүжилтийн зарцуулалт, салбараар



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

2020 онд явуулсан судалгаагаар ААН-үүдийн хувьд санхүүжилтээ эргэн төлөхөд тулгардаг хамгийн гол хүндрэл нь “зээлийн хүү өндөр” (77%) гэсэн бол энэ жилийн хувьд цар тахалтай холбоотойгоор бизнесийн дотоод орчин муудсан нь ААН-ийн үйл ажиллагаанд хамгийн сөргөөр нөлөөлсөн (20%) гэсэн үр дүн гарлаа. Түүнчлэн төгрөгийн ханш (юань-төгрөг) болон инфляц өндөр дарамт үзүүлж байна (тус тус 14%) гэж хариулсан байна.

#### Дүрслэл 4.11 | Санхүүжилтээ эргэн төлөхөд тулгардаг бэрхшээл



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

ААН-үүдийн талаас илүү хувь нь буюу 55% нь 50-500 сая төгрөгийн санхүүжилт нь үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлнэ гэж хариулсан байна. Харин нийт ААН-үүдийн 19 хувь нь өндөр дүнтэй буюу 500 сая төгрөгөөс дээш санхүүжилтийг үйл ажиллагаандаа зориулан авч ашиглах хүсэлтэй байна.


#### Дүрслэл 4.12 | Үйл ажиллагаанд дэмжлэг санхүүжилтийн хэмжээ



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн хувьд 34% нь буюу голлон бичил болон жижиг ААН-үүд 3-5 жилийн хугацаатай санхүүжилт авах сонирхолтой байгаа бол 24% нь буюу жижиг, дунд ААН-үүд 5-10 жилийн хугацаатай санхүүжилт үйл ажиллагаанд нь хэрэгцээтэй байна гэсэн байна.


**Дүрслэл 4.13 | Бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хугацаа, салбараар**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Шаардлагатай санхүүжилтийн хэмжээ, хугацаа нь ААН-үүдийн хэмжээтэй шууд хамааралтай байна. Тухайлбал бичил ААН-үүдийн хувьд дунджаар 4 жилийн хугацаатай 326 сая төгрөгийн санхүүжилт үйл ажиллагаанд дэмжлэг болно гэсэн бол том ААН-үүд дунджаар 5-с дээш жилийн хугацаатай 1.4 тэрбум төгрөгөөс дээш санхүүжилт шаардлагатай гэсэн байна.

**Дүрслэл 4.14 | Бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх санхүүжилтийн хэмжээ, хугацаа, ААН-ийн хэмжээгээр**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Салбаруудын хувьд хамгийн өндөр санхүүжилтийн хэмжээ барилгын салбарт шаардлагатай байгаа бол урт хугацаат санхүүжилт аж үйлдвэрлэлийн салбарт хэрэгцээтэй байна.


**Дүрслэл 4.15 | Бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх санхүүжилтийн хэмжээ, хугацаа, ААН-ийн хэмжээгээр**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Орон нутагтай харьцуулахад Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдийн шаардлагатай зээлийн хэмжээний дундаж өндөр байгаа бол хугацаа нь харьцангуй богино байна.

**Дүрслэл 4.16 | Бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх санхүүжилтийн хэмжээ, хугацаа, байршлаар**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

## ЦАР ТАХАЛ, ЗАСГИЙН ГАЗРЫН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН НӨЛӨӨ

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор судалгаанд хамрагдсан ААН-үүдийн 17% нь цаашид ажилтнуудаа бүр болон түр чөлөөлөх, 15% нь ажлын цагаа бууруулахаар төлөвлөж байна. Харин 29% нь үйл ажиллагаа хэвийн үргэлжлүүлэх төлөвтэй байна.

- Засгийн газрын хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдээс бизнест хамгийн ихээр эерэг нөлөө үзүүлж, дэмжлэг болсон нь ААНБ-уудын НДШ тэглэх арга хэмжээ /47%/ болсон байна.
- Ажлын байрыг хадгалах 3%-ийн хүүтэй зээлийн хөтөлбөрийн хүртээмж муу, шалгуур өндөр байснаас шалтгаалан ихэнх ААН-үүд хамрагдаж чадаагүй байна.
- Цар тахалтай холбоотой үүсэн ачаа тээврийн асуудлаас шалтгаалан тээврийн зардал нэмэгдсэн нь барилга, дотоод худалдаа салбарт ихээхэн дарамт үзүүлсэн байна.

### БҮЛЭГ 1

*Ерөнхий  
мэдээлэл*

### БҮЛЭГ 2

*Бизнесийн  
орчин*

### БҮЛЭГ 3

*Бизнесийн  
үйл  
ажиллагаа*

### БҮЛЭГ 4

*Санхүүжилт,  
дэмжлэг*

### БҮЛЭГ 5

*Цар тахал,  
ЗГ-ын төсөл  
хөтөлбөрийн  
нөлөө*



## 5. ЦАР ТАХАЛ, ЗГ-ЫН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН НӨЛӨӨ

Энэ жилийн судалгаанд цар тахалтай холбоотойгоор бизнес эрхлэгчдийн зүгээс цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, мөн цар тахлын үед Засгийн газрын зүгээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь ААН-үүдийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлсөн талаарх санал, асуулгын үр дүнг энэ бүлэгт танилцуулна.

Судалгааны үр дүнгээс харахад Ковид-19 цар тахалтай холбоотойгоор цаашид нийт ААН-үүдийн 29% нь хэвийн ажиллах, 17% нь ажилтнуудаа бүр болон түр чөлөөлөх, 15% нь ажлын цагаа бууруулах, 12% нь үйл ажиллагааны зардлаа бууруулахаар төлөвлөж байна. Мөн 2%-7% нь үйл ажиллагааны бүрэн болон тодорхой хэсгийг зогсоох, зарим зардлаа дараа төлөхөөр хойшлуулах, төлөвлөсөн хөрөнгө оруулалтаа зогсоох болон бусад арга хэмжээг авахаар төлөвлөж байна.

**Дүрслэл 5.1 | Цар тахалтай холбоотойгоор цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Төр засгийн зүгээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдээс ААН-үүдийн үйл ажиллагаанд хамгийн ихээр эерэг нөлөө

үзүүлж, дэмжлэг болсон нь ААН-үүдийн НДШ-ийг тэглэх, ажлын байрыг хадгалах 3%-ийн хүүтэй зээл олгох, 1.5 тэрбум төгрөгөөс доош орлоготой ААН-үүдийг ААНОАТ-аас чөлөөлөх арга хэмжээнүүд болсон байна. Мөн ус цахилгааны төлбөрийг тэглэх, ноос ноолуурын урамшуулал олгох зэрэг арга хэмжээнүүд ААН-үүдэд эерэг нөлөө үзүүлсэн байна.

**Дүрслэл 5.2 | Засгийн газраас хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдээс эерэг нөлөө үзүүлж, дэмжлэг болсон арга хэмжээ**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Хэдийгээр ААН-үүдийн НДШ-ийг тэглэх арга хэмжээнд харьцангуй бага санхүүжилт зарцуулсан /Дүрслэл 5.3/ хэдий ч ААН-үүдийн зүгээс өндөр дэмжлэг авсан байгаа нь цаашид хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн боловсруулах үед анхаарах хэрэгтэйг харуулж байна.


**Дүрслэл 5.3 | Засгийн газраас хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн зарцуулалт /2021.07.01-ний байдлаар/**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Судалгаанд оролцогчдын 23% нь Ажлын байрыг хадгалах 3%-ийн хүүтэй зээлд хамрагдсан байна /Дүрслэл 5.4/.

**Дүрслэл 5.4 | Ажлын байрыг хадгалах 3 хувийн хүүтэй зээлд хамрагдсан эсэх**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Тус зээлийн хөтөлбөрт ААН-үүд зээлийн хүртээмж муу /32%/, шалгуур өндөр /23%/, хэрэгцээ шаардлага гараагүй /14%/ зэрэг шалтгааны улмаас хамрагдаагүй байна /Дүрслэл 5.5/.


**Дүрслэл 5.5 | Ажлын байрыг хадгалах 3 хувийн хүүтэй зээлд хамрагдаагүй шалтгаан**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Гадаад худалдаанд үүссэн ачаа тээврийн гацалт үүссэн нь хамгийн ихээр барилга /63%/, аж үйлдвэр /55%/-ийн салбарт нөлөөлсөн байна /Дүрслэл 5.6/.

**Дүрслэл 5.6 | Гадаад худалдаанд ачаа тээврийн гацалт үүссэн эсэх**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

Гадаад худалдаанд ачаа тээврийн гацалт үүссэн нь судалгаанд хамрагдсан ААН-үүдийн 78%-ийнх нь тээврийн зардлыг нэмэгдүүлсэн бол 11%-ийнх нь нийлүүлэлтэд сөргөөр нөлөөлсөн гэж хариулжээ.

**Дүрслэл 5.7 | Гадаад худалдаанд ачаа тээврийн гацалт нөлөөлсөн байдал**



Эх сурвалж: Бизнесийн түүвэр судалгаа, Монголбанк (2021)

## 6. ДҮГНЭЛТ

Судалгаанд 5-20 жилийн хугацаанд дотоод худалдаа болон үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхэлж буй бичил, жижиг ААН-үүд түлхүү хамрагдлаа. ААН-үүдийн зүгээс хэдийгээр бизнесийн орчин бизнесийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөтэй байгаа хэдий ч өмнөх оноос сайжирч цар тахлын өмнөх үеийн түвшинд дөхөж очсон гэж хариулсан байна. Бизнесийн орчин Увс, Сүхбаатар аймагт хамгийн муу байгаа бол Говь-Алтай, Баян-Өлгий аймагт сайн байна судалгаанд оролцогчид үнэлжээ.

Макро эдийн засгийн түвшинд үнийн өсөлт, юанийн эсрэг төгрөгийн ханш суларсан нь өндөр дарамт болж байна. Ядуурал, ажилгүйдэл өндөр байгаа нь асуудал дагуулсан хэвээр байна. Түүнчлэн энэ жилийн тухайд гадаад худалдаа хийх, газар эзэмших боломж хүндрэлтэй байгаа нь ААН-үүдийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөлж байна гэж үзлээ.

Улсын хэмжээнд иргэдийн худалдан авах чадвар буурсан дүр зурагтай байна. Зам тээврийн нөхцөл байдал нь сөрөг нөлөө үзүүлж байгаа бол мэдээлэл, харилцаа холбоо, цахилгаан, усан хангамжийн нөхцөл байдал гарсан өөрчлөлт нь дэмжлэг болжээ. Санхүүжилтийн хувьд бүх үзүүлэлтүүдийн сөрөг нөлөөлөл буурсан дүр зурагтай байна.

Цар тахалтай холбоотойгоор ажиллах хүчний нийлүүлэлт, ур чадвар дээр хүндрэл үүссэн нь үйл ажиллагаанд нь сөргөөр нөлөөлж байна гэж судалгаанд хамрагдсан

ААН-үүд үзжээ. Түүнчлэн ААН-үүдийн олонхийг бүрдүүлж буй бичил ААН-үүдийн орлого буурсан бол түүхий эд материалын зардал, төрийн шимтгэл хураамж нь ААН-үүдийн үйл ажиллагаанд өндөр дарамт үзүүлж байна. Хүчин чадлын ашиглалт оргил үеэс мэдэгдэхүйц буурсан дүр зурагтай байна.

ААН-үүдийн тал хувь нь өөрсдийн дотоод үйл ажиллагааны орлогоороо санхүүжилтийн хэрэгцээгээ хангадаг гэж хариулсан хэдий ч цар тахалтай холбоотойгоор борлуулалтын орлого буурснаас эргэлтийн хөрөнгийн зээлийн санхүүжилтийн хэрэгцээ шаардлага нэмэгдсэн байна. Зээлээ эргэн төлөхөд эдийн засаг, бизнесийн орчин, үнийн өсөлт зэрэг нь хүндрэл учруулж байна. Түүнчлэн ААН-үүдийн зүгээс банк болон төр, засгаас бага өртөгтэй санхүүжилт, татварын таатай орчин, чирэгдэлгүй төрийн үйлчилгээ зэргийг хүлээж байна. Мөн өнгөрсөн 1 жилийн хугацаанд Засгийн газрын зүгээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдээс НДШ болон ААНОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт болон ажлын байрыг хадгалах 3%-ийн хөтөлбөр зэрэг арга хэмжээнүүд нь хамгийн ихээр дэмжлэг болсон гэж хариуллаа.

Эцэст нь ААН-үүдийн хувьд үнийн өсөлтийг хязгаарлах, иргэдийн худалдан авах чадварыг сайжруулах, гадаад худалдааны асуудлыг цэгцлэх, ур чадвартай ажиллах хүчин бэлтгэхэд анхаарах, татварын таатай орчин бүрдүүлэх нь бизнесийн хэвийн үйл ажиллагаанд нэн тэргүүний шаардлагатай арга хэмжээ гэж үзсэн байна.

## 7. ХАВСРАЛТ

### 7.1 Асуулгын хуудас

Монголбанкны бизнесийн түүвэр судалгаа

Мягт ТС-1



#### БИЗНЕСИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА-2021

Энэхүү судалгааны зорилго нь ААН-үүдийн бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйлс, учирч буй саад бэрхшээл, санхүүжилтийн байдал, үзүүлж буй дэмжлэгийн талаар судлахын зэрэгцээ үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалт, орлого зарлагын байдлыг тодорхойлоход оршино. Судалгааны дүнг нэгтгэсэн тоон үзүүлэлтээр гаргах бөгөөд байгууллагын нууцлалыг "Төв банкны тухай хууль"-ийн 34-р зүйлийн 3 дахь хэсэг, "Байгууллагын нууцын тухай", "Статистикийн тухай" Монгол Улсын хуулийн дагуу халгална.

#### 1. АЖ АХУЙН НЭГЖИЙН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр:						
Үйл ажиллагаа эрхэлж буй газрын нэр (аймаг/хот):						
Хаяг:						
Утас:						
Бизнесийн үйл ажиллагааны голдох төрлийг сонгоно уу.						
Ерөнхий салбар	Салбарын ангилал	Код	Ерөнхий салбар	Салбарын ангилал	Код	
ХАА	Хөлөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1	Үйлчилгээ	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	8	
	Аж үйлдвэр	Уул уурхай, олборлолт		2	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	9
		Боловсруулах үйлдвэрлэл		3	Мэдээлэл, холбоо	10
		Цахилгаан, хий, уур, хангамж		4	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	11
	Барилга	Усан хангамж		5	Үл мөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	12
		Барилга		6	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	13
	Дотоод худалдаа	Бөөний болон жижиглэн худалдаа		7	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	14
Боловсрол					15	
				Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	16	
				Урлаг, үзвэр, тоглоом наадам	17	
				Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	18	

#### 2. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ (харгалзах үнэлгээг "✓" гэж тэмдэглэнэ үү)

##### 2.1. Тавай байгууллагын харвцлагын хэлбэр

Сонголт	Код
Хувиараа эрхлэх аж ахуй	□
ХХК	□
ХК	□
Хоршоо	□
Нөхөрлөл	□
ТББ	□
Бусад	□

##### 2.2. Үйл ажиллагааны чиглэл /олон сонголттой/

Сонголт	Код
Хөлөө аж ахуй	□
Уул уурхай	□
Боловсруулах үйлдвэрлэл	□
Барилга	□
Дотоод худалдаа	□
Үйлчилгээ	□
Бусад	□

##### 2.3. Үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа

Сонголт	Код
1 жил хүртэл	□
1-3 жил	□
3-5 жил	□
5-10 жил	□
10-20 жил	□
20-30 жил	□
30-с дээш жил	□

##### 2.4. Ажиллагчдын тоо

Сонголт	Код
10 хүртэл	□
10-19	□
20-49	□
50-100	□
100-200	□
200-с дээш	□

##### 2.5. Жвлийн нийт орлого

Сонголт	Код
5 сая төгрөг хүртэл	□
5-10 сая төгрөг	□
10-50 сая төгрөг	□
50-100 сая төгрөг	□
100-300 сая төгрөг	□
300-500 сая төгрөг	□
500 саяас-1 тэрбум төгрөг	□
1-2.5 тэрбум төгрөг	□
2.5 тэрбум төгрөгөөс дээш	□

##### 2.6. Хөрөнгө оруулалтын хэлбэр

Сонголт	Код
Дотоодын хөрөнгө оруулалттай	□
Гадаадын хөрөнгө оруулалттай	□
Холимог	□

##### 2.7. Гадаад худалдаа эрхэлдэг эсэх

Сонголт	Код
Тийм	□
Үгүй	□

## 3. БИЗНЕСНИЙ ОРЧИНД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛС (харгалзах үнэлгээг "✓" гэж тэмдэглэнэ үү)

	Маш муу	Муу	Дунд	Сайн	Маш сайн	Мэдээгүй
<b>3.1. Макро эдийн засгийн нөлөө</b>						
1	Эдийн засгийн өсөлт					
2	Инфляц (үнийн өсөлт)					
3	Валютын ханш					
4	Гадаадын шууд хөрөнгө оруулалт					
5	Гадаад өр					
<b>3.2. Нийгэм, улс төрийн байдал</b>						
1	Ядуурал					
2	Ажигүйдэл					
3	Гэмт хэрэг					
4	Хээл хамууль					
5	Улс төрийн байдал					
<b>3.3. Хууль эрх зүй, төрийн зохицуулалт</b>						
1	Хуулийн хэрэгжилт					
2	Татварын (хураамж) тогтолцоо					
3	Гадаад худалдаа хянг нөхцөл					
4	Төрийн байгууллагын үйлчилгээ					
5	Хяналт, шалгалтын тогтолцоо					
6	Газар эзэмших боломж					
<b>3.4. Зах зээлийн орчин</b>						
1	Хэрэглэгчдийн худалдан авах чадвар					
2	Зах зээлийн багтаамж					
3	Зах зээлийн өрсөлдөөн					
4	Мэдээллийн хүртээмж					
5	Технологийн дэвшил					
<b>3.5. Дэд бүтцийн төгжил</b>						
1	Зам					
2	Тээвэрлэлт					
3	Дулааны шугам сүлжээ					
4	Усан хангамж					
5	Цахилгаан түгээлт					
6	Мэдээлэл холбоо					
<b>3.6. Санхүүжилтийн орчин</b>						
1	Зээлийн хүү					
2	Зээлийн хугацаа					
3	Зээлийн хэмжээ					
4	Зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээ					
5	Зээлийн шийтгэл, хураамж					
6	Зээлийн батлан даалт					
<b>3.7. Дотоод хүчин зүйлс</b>						
1	Ажиллах хүчний нийтлүүлэлт					
2	Ажиллах хүчний үр чадвар					
3	Түүхий эдийн олдоц					
4	Тоног төхөөрөмжийн чанар					
5	Өрсөлдөх чадвар					
6	Шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх боломж					
7	Барилга байгууламжийн хуралцээ					
8	Бараа, бүтээгдэхүүний борлуулалт					



## 4. БИЗНЕСНИН САНХҮҮЖИЛТ (харгалзах кодыг дугуйлна уу)

№	Асуулт	Сонголт	Код	№	Асуулт	Сонголт	Код
4.1	Бизнесийн үйл ажиллагааны санхүүжилтээ голчлон хаанаас авдаг вэ?	Өөрсдөө /асуулт 4.3 рүү очно уу/	1	4.4	Банк санхүүгийн байгууллагаас зээл авахад ямар хүндрэл учирдаг вэ? /3 хуртал сонголттой/	Бичиг баримт бүрдүүлэлт	1
		Гадаадын байгууллага /асуулт 4.3 рүү очно уу/	2			Бизнес төлөвлөгөө боловсруулахад	2
		Дотоодын байгууллага	3			Зээлийн нөмцөл хагуу	3
4.2	Хэрэв дотоодын байгууллагаас санхүүжилт (зээл) авдаг бол хаанаас авдаг вэ? /3 хуртал сонголттой/	Банк	1			Барьцаа хөрөнгийн үнэлгээ доогуур	4
		ББСБ	2			Батлан даалтад хамрагдаж чаддаггүй	5
		ХЗХ	3			Банкны салбарын мунд суртал	6
		Барьцаалан зээлдүүлэх	4			Орлогын нотолгоо хангалтгүй	7
		Хөнгөлөлттэй төслийн зээл	5			Тогтмол орлогогүй	8
		Хувьцаа гаргах	6			Авилга, хээл хахууль шаарддаг	9
		Бонд гаргах	7			Шинэтгэл мураамж өндөр	10
		ЗГ-ын тусгай сан	8			Бусад	11
		Бусад ААНБ	9	.....			
		Хувь хүн	10				
Бусад	11						
4.3	Санхүүжилтээ голчлон юунд зарцуулдаг бэ? /3 хуртал сонголттой/	Эргэлтийн хөрөнгө	1	4.5	Зээлийн санхүүжилтээ эргэн төлөхөд ямар бэрхшээл тулгардаг вэ? /3 хуртал сонголттой/	Микро эдийн засаг хүндэрсэн	1
		Барилгаа өргөжүүлэх, худалдаж авах	2			Бизнесийн орчин муудсан (дотоод)	2
		Машин, техник тоног төхөөрөмж	3			Гадаад худалдаанд саад гарсан	3
		Хүний нөөцийн бодлого	4			Төгрөгийн ханш суларсан	4
		Зар сурталчилгаа	5			Хэрэглээний барааны үнэ өссөн /инфляц/	5
		Судалгаа шинжилгээ	6			Төр засгийн үйл ажиллагаанаас шалтгаалж	6
		Бизнесээ өргөжүүлэх	7			Зээлийн нөмцөл хагуу байсан	7
		Өөр бизнес эрхлэх	8			Бусад давагдашгүй хүчин зүйлс	8
		Зээлээ төлөх	9			Бусад	9
		Бусад	10	.....			
4.6	Цаашид үйл ажиллагаа хэвийн явуулахад хэднй хэмжээний санхүүжилт шаардлагатай байна вэ?	5 сая төгрөг хүртэл	1	4.7	Таны бизнесийн үйл ажиллагаанд ямар хугацааны санхүүжилт дэмжлэг үзүүлэх вэ?	1 жил хүртэл	1
		5-10 сая төгрөг	2			1-3 жил	2
		10-50 сая төгрөг	3			3-5 жил	3
		50-100 сая төгрөг	4			5-10 жил	4
		100-300 сая төгрөг	5			10-с дээш жил	5
		300-500 сая төгрөг	6			Мэдэггүй	6
		500-1 тэрбум төгрөг	7				
		1-2.5 тэрбум төгрөг	8				
		2.5 тэрбум төгрөгөөс дээш	9				
		Мэдэггүй	10				



**5. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ** (тохирох харуулгыг бөглөнө үү.)

**5.1. Тавай байгууллагын нийт зардал өнгөрсөн жилтэй харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөн вэ?**

Сонголт	Код
Өссөн	□
Буурсан	□
Өөрчлөгдөөгүй	□

**5.2. Тавай байгууллагын зүгээс нийт зардлаа бууруулах ямар боломж байна вэ? /3 хүртэл сонголттой/**

Сонголт	Код
1	Түүхий эд, материалын өртгийг бууруулах □
2	Ажиллах хүчний цалин хөлсийг бууруулах □
3	Ажиллах хүчний тоог бууруулах □
4	Үйл ажиллагааны бусад зардлаа бууруулах □
5	Бизнесийн үйл ажиллагаагаа хумих □
6	Санхүүгийн зардлаа бууруулах □
7	Борлуулалт, маркетингийн зардлаа бууруулах □
8	Зардлаа бууруулах бусад боломжийг бичнэ үү. ..... ..... .....

**5.3. Зардлын байдал (харгалзах үнэлгээг "✓" гэж тэмдэглэнэ үү)**

Сонголт	Маш их хүндрэлтэй	Их хүндрэлтэй	Дунд хүндрэлтэй	Бага хүндрэлтэй	Хүндрэлгүй	Мэлэггүй
1	Түрээсийн зардал					
2	Түүхий эд материалын зардал					
3	Тоног төхөөрөмжийн зардал					
4	Хүний нөөцийн зардал (цалин, урамшувал г.м)					
5	Дулааны зардал					
6	Усны зардал					
7	Цахилгааны зардал					
8	Зам, тээврийн зардал					
9	Үйл ажиллагааны бусад зардал					
10	Харилцаа холбоо, борлуулалт, маркетингийн зардал					
11	Зээлийн хүүний зардал					
12	Хураамж шимтгэл (санхүүгийн байгууллагын)					
13	Татвар шимтгэл, хураамжийн төлбөр (төрийн үйлчилгээ)					

**6. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО** (тохирох хариултыг бөглөнө үү.)

**6.1. Тавай байгууллагын нийт орлого өнгөрсөн жилтэй харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөн вэ?**

Сонголт	Код
Буурсан	□
Өссөн	□
Өөрчлөгдөөгүй	□

**6.2. Тавай байгууллагын орлогын голлох төрөл аль нь вэ?**  
*/3 хуримал сонголттой/*

Сонголт	Код
1 Үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлого (бараа ажил, үйлчилгээ)	□
2 Түрээсийн орлого	□
3 Ногдол ашгийн орлого	□
4 Хүүний орлого	□
5 Үл мөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого	□
6 Эрхийн шимтгэлийн орлого (лиценз, патент, франчайзинг)	□
7 Биег бус хөрөнгө болон мөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого	□
8 Төрийн байгууллагаас олгосон эрх борлуулсан, шилжүүлсний орлого	□
9 Хувьцаа, үнэт цаас, санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсны орлого	□
10 Гадаад валютын ханшийн зөрүүний орлого	□
11 Даатгалын нөхөн төлбөр	□
12 Бусад орлого	□

**6.3. Тавай байгууллагын зүгээс нийт орлогоо өсгөх ямар боломж байна вэ?** */3 хуримал сонголттой/*

Сонголт	Код
1 Ажлын бүтээмжийг дээшлүүлэх	□
2 Борлуулалтын үйл ажиллагааг слайжруулах, илэвжүүлэх	□
3 Зорилтот бүлэг, борлуулалтын байршлаа өөрчлөх	□
4 Үйлдвэрлэлийн тоо хэмжээг нэмэгдүүлэх	□
5 Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг нэмэгдүүлэх	□
6 Шинэ технологи нэвтрүүлэх	□
7 Шинэ бараа, үйлчилгээ нэвтрүүлэх	□
8 Бизнесээ гэлэх, өргөжүүлэх	□
9 Үндсэн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаа эрхлэх	□
10 Бусад	□

**7. ХҮЧИН ЧАДЛЫН АШИГЛАЛТ** (нөхөж бичнэ үү)

**7.1. Бизнесийн үйл ажиллагааныхаа** *(үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа)* хэдэн хувийг ашиглаж байна вэ?

Сонголт	Код
.....%	

**7.2. Та үйлдвэрлэл, үйлчилгээндээ** тоног төхөөрөмж ашигладаг уу?

Сонголт	Код
Тийм	□
Үгүй /асуулт 7.4 рүү очно уу/	□

**7.3. Та тус тоног төхөөрөмжийнхөө** боломжит хүчин чадлын хэдэн хувийг ашигладаг вэ?

Сонголт	Код
1 Сүүлийн 3 жилийн дундаж <i>(2019 оноос)</i>	.....%
2 Ковид гарснаас хойшхи дундаж <i>(2020.02 сараас)</i>	.....%

**7.4. Та өөрийн эрхэлдэг үйл ажиллагааны хүчин чадалтай холбоотой дараах мэдээллийг нөхөж бичнэ үү?**

Сонголт	Хамгийн өндөр орлоготой байсан жил	2020 он	2021 он
1 Ажилчдын тооны дундаж	.....	.....	.....
2 Нэг ажилтны өдөрт ажиллах цагийн дундаж	.....	.....	.....
3 Сарын дундаж орлого /төгрөгөөр/	.....	.....	.....

## 8. ТӨРНИН БОЛОН БУСАД ДЭМЖЛЭГҮҮД (харгалзах үнэлгээг "✓" гэж тэмдэглэнэ үү)

8.1. Таны бодлоор бизнесийн байгууллагыг тэмгнн ихээр дэмжлэг байгууллага аль нь вэ? /3 хуртал сонголттой/	Код	
1	УИХ, Засгийн газар	□
2	Орон нутгийн засаг захиргаа	□
3	Олон улсын байгууллагууд	□
4	Банкууд	□
5	Бусад санхүүгийн байгууллагууд	□
6	Төрийн бус байгууллагууд	□
7	Худалдаа, аж үйлдвэрийн танхим	□
8	Ажил олгогч эдийн холбоо	□
9	Үйлдвэрчний эвлэл	□
10	Зөвлөгөө өгөх байгууллага, төвүүд	□
11	Мэдээгүй	□
12	Бусад	

8.2. Дээрх байгууллагуудаас ямар дэмжлэг үзүүлж байна вэ? /3 хуртал сонголттой/	Код	
1	Санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгосон	□
2	Бизнес эрхлэгчдийн эрх зүйн орчинг сайжруулсан	□
3	Татварын бодлогоор дэмжсэн	□
4	Дэд бүтцийг сайжруулсан	□
5	Сургалт, зөвлөгөө явуулсан	□
6	Технологийн ололт, дэвшилийг нэвтрүүлсэн	□
7	Бизнесийг дэмжих инкубатор төвүүдийг байгуулсан	□
8	Бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чөлөөг нэмэгдүүлсэн	□
9	Бизнесүүдийн тоног төхөөрөмжийг НӨАТ-аас чөлөөлсөн	□
10	Үзэсгэлэн, худалдаа зохион байгуулсан (маркетинг)	□
11	Дэмжлэг үзүүлдэггүй	□
12	Мэдээгүй	□
13	Бусад	

8.3. Бизнесийг хөгжүүлэхэд бодлогын хэмжээнд нэн гурүүнд ямар арга хэмжээг авбал зохистой вэ? /3 хуртал сонголттой/	Код	
1	Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох	□
2	Авилгыг бууруулах	□
3	Зөвшөөрөл, лицензийн тоог багасгах	□
4	Хууль, эрх зүйн орчинг сайжруулах	□
5	Бизнестэй холбоотой шийдвэрт хувийн хэвшил, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх	□
6	Хяналт, шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох	□
7	Татварын таатай орчинг бүрдүүлэх	□
8	Албан зөвшөөрлийн хураамжийг бууруулах	□
9	Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих	□
10	Хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэрийн хүртээмжийг өсгөх	□
11	Мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх	□
12	Сургалт, зөвлөгөө өгөх үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх	□
13	Үйлдвэрлэл, технологийн төв байгуулах	□
14	Шинэ технологийг саналчлагч ААН-үүдийг тусгайлан дэмжих	□
15	Дэд бүтцийг сайжруулах	□
16	Маркетингийн тал дээр дэмжлэг үзүүлэх	□
17	Мэдээгүй	□
18	Бусад	

## 9. БУСАД (харгалзах кодыг /тоог/ дугуйна уу, нөхөж бичнэ үү )

№	Асуулт	Сонголт	Код
9.1	Танай байгууллага Ковидтой холбоотойгоор цаашид ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх вэ? /3 хуртал сонголттой/	Ажилтнуудад бүр болон гур чөлөөлөх	1
		Ажлын цагаа бууруулах	2
		Үйл ажиллагааны зардлаа бууруулах	3
		Үйл ажиллагаагаа бүрэн болон тодорхой хэсгийг зогсоох	4
		Төлөвлөсөн хөрөнгө орчуулалтаа зогсоох	5
		Эрсдэлээс хамгаалах нөөц бүрдүүлэх	6
		Зарим зардлаа дараа төлөхөөр хойшлуулах	7
		Хэвийн ажиллах	8
		Бусад арга хэмжээг бичнэ үү. ..... ..... .....	9
9.2	Төр засгийн зүгээс авч хэрэгжүүлсэн дараах арга хэмжээнүүдээс танил бизнест хамгийн ихээр зэрэг нөлөө үзүүлж, дэмжлэг болсон 3 хуртамх арга хэмжээг сонгоно уу.	ААНБ-уудын НЦШ тэглэх	1
		1.5 тэрбум төгрөгөөс доош орлоготой ААНБ-уудад ААНОАТ-аас чөлөөлөх	2
		Ажлын байрлаа хадгалах байгаа ААНБ-уудын ажилтнуудад сар бүр 200,000 төгрөгийн дэмжлэг олгох	3
		Шатахууны үнийг тогтворжуулах ЗГ-ын хөтөлбөр	4
		Зээлийн нүүт бууруулах стратеги	5
		Зээл, зээлийн нүүтийн төлөлтийг хойшлуулах	6
		Ноос, ноолуурын урамшуулал олгох	7
		Ажлын байрыг хадгалах 3%-ийн нүүтэй зээл олгох	8
		Ус, цахилгааны төлбөрийг тэглэх	9
		Бусад ..... ..... .....	10
9.3	Танай байгууллага ажлын байрыг хадгалах 3%-ийн нүүтэй зээлд хамрагдсан уу?	Тийм /асуулт 9.5 руу очно уу/	1
		Үгүй	2
9.4	Ажлын байрыг хадгалах 3%-ийн нүүтэй зээлд хамрагдаагүй шалтгаан юу вэ? /3 хуртал сонголттой/	Зээлийн хүртээмж муу	1
		Зээлийн шалгуур өндөр	2
		Барьцаа хөрөнгө хангалтгүй	3
		НӨАТ төлөгч биш	4
		Санхүүгийн харьцаа үзүүлэлтийн шаардлагыг хангаагүй	5
		Банхуудын ачаалал их	6
		Мэдээлэл муу	7
		Хүнд суртал	8
		Хэрэгцээ шаардлага гараагүй	9
		Бусад ..... ..... .....	10
9.5	Танай байгууллагын гадаад худалдаанд ачаа тээврийн гацалт үүссэн эсэх?	Тийм	1
		Үгүй /асуулт 9.7 руу очно уу/	2
9.6	Танай байгууллагын гадаад худалдаанд ачаа тээврийн гацалт ямар байдлаар нөлөөлсөн бэ? /3 хуртал сонголттой/	Тээврийн зардал нэмэгдсэн	1
		Түүхий эд материалын үнэ нэмэгдсэн	2
		Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт буурсан	3
		Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт зогссон	4
		Бусад ..... ..... .....	5
9.7	Танай бизнесийн үйл ажиллагааны хувьд том дэвсгэртэй хэрэгцээ шаардлага байгаа юу? /50,000Т, 100,000Т/	Тийм	1
		Үгүй	2
Ковидтой холбоотойгоор танай бизнесийн үйл ажиллагааг хэвийн явуулах, орчныг сайжруулахад тулгамдаж буй асуудлын талаар нэмэлт саналаа бичиж үлдээнэ үү: ..... ..... ..... .....			